



**МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН**

**ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭНГИЙН
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ
(2018-2025)**

**УЛААНБААТАР
2019**

Шинжлэх ухааны Академийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэн
(ТУХ)-ийн 2018-2025 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө

Хүрээлэнгийн 2018-2025 оны стратегийн төлөвлөгөөтэй холбоотой санал, хүсэлтийг дараах утас, факс, эмайл хаягаар ирүүлнэ үү.

Утас: 976-11-458305, 455028, 99098310

Факс: 976-11-458305

Емайл: history@mas.ac.mn
Samchuluun@gmail.com

АГУУЛГА

ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн “Стратеги төлөвлөгөө”-ний товч хураангуй

- Хүрээлэнгийн товч түүх
- Хүрээлэнгийн “Алсын хараа”
- Хүрээлэнгийн “Эрхэм зорилго”
- Хүрээлэнгийн “Үнэт зүйлс”
- Хүрээлэнгийн хамрах цар хүрээ

Нэг. Стратеги төлөвлөгөө боловсруулах үндэслэл, зарчим, ач холбогдол

- Стратеги төлөвлөгөө боловсруулсан нийтлэг үндэслэл
- Стратеги төлөвлөгөө боловсруулсан үндсэн зарчмууд

Хоёр. Хүрээлэнгийн үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ

- Хүрээлэнгийн хөгжлийн төлөв байдал
- Хүрээлэнгийн эрдэм судалгааны онол, арга зүйн түвшин
- Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний үйл ажиллагааны орц, гарцын шинжилгээ
- Хүрээлэнгийн үйл ажиллагааны SWOT шинжилгээ

Гурав. Хүрээлэнгийн стратеги зорилтууд (2018-2025 он)

3.1. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах судалгаа боловсруулалтын зорилт

- Евразийн нүүдэлчид, эртний төрт улсын түүх, археологийн судалгааны салбарын зорилт
- Монголын эзэнт гүрэн ба дундад зууны судалгааны салбарын зорилт
- Орчин үе, бүс нутгийн судалгааны салбарын зорилт
- Угсаатан, нийгэм-соёлын хүн судлалын судалгааны салбарын зорилт
- Хэрэглээний угсаатан судлал, биет бус соёлын өвийн төвийн зорилт
- Сурвалж судлал, түүхийн баримт, мэдээлэлийн төвийн зорилт

3.2. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны зорилтууд

- Хүрээлэнгийн удирдлага, менежментийн оновчлол
- Хүрээлэнгийн боловсон хүчний нөөц бололцоо чадавхийг дээшлүүлэх
- Хүрээлэнгийн техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх
- Хүрээлэнгийн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх
- Хүрээлэнгийн дэд бүтэц, судалгааны бүс нутгийн төвүүдийг байгуулах

Дөрөв. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үе шатууд

- Хүрээлэнгийн 4 жилийн хөгжлийн төлөвлөгөө
- Хүрээлэнгийн нэг жилийн үр дүнгийн гэрээний төлөвлөгөө

Тав. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн хүрээ, боломж

- Дотоод хүрээ, боломж

- Гадаад хүрээ, боломж

Зургаа. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ, хяналт, үнэлгээ

- Стратеги зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилт, төлөвлөгөөт арга хэмжээ
- Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх хөрөнгө, санхүүжилт
- Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

Хавсралт №1.

Хүрээлэнгийн үүсэл, хөгжил

- Евразийн нүүдэлчид, эртний төрт улсын түүх, археологийн судалгааны салбар
- Монголын эзэнт гүрэн ба дундад зууны судалгааны салбар
- Орчин үе, бүс нутгийн судалгааны салбар
- Угсаатан, нийгэм-соёлын хүн судлалын судалгааны салбар
- Хэрэглээний угсаатан судлал, биет бус соёлын өвийн төв
- Сурвалж судлал, түүхийн баримт, мэдээлэлийн төв

Хавсралт №2.

Үйл ажиллагааны өнөөдрийн төлөв байдал

ШУА-ИЙН ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭНГИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОВЧ ХУРААНГУЙ

“ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн стратеги төлөвлөгөө” /цаашид Стратеги төлөвлөгөө гэх/-г боловсруулахдаа Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Шинжлэх ухаан технологийн тухай хууль, Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хууль, Соёлын өвийн тухай хууль ба бусад холбогдох хуулийг тулгуур болгож, Шинжлэх ухаан технологийн талаар төрөөс баримтлах бодлого, Монгол улсын Ерөнхийлөгчийн “Эх хэл, түүх, соёлоо судлах, хөгжүүлэх ажлыг дэмжих тухай” 162-р зарлиг, Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөр, ШУА-ийн ерөнхийлөгч, академич Д.Рэгдэлийн мөрийн хөтөлбөр, ШУА-ийн ТУХ (цаашид Хүрээлэн гэх)-ийн захирал, академич С.Чулууны мөрийн хөтөлбөр зэрэг баримт бичгүүдийн зорилт, үзэл санаатай нягт уялдуулав.

“Алсын хараа”

Монголын түүх, соёлын суурь судалгааг үндэсний хэмжээнд тэргүүлэн, бүс нутаг болон олон улсын түвшинд явуулж, дэлхийн монгол судлалын төвийн байр сууриа хадгалах, хүн төрөлхтөний соёлын нэгэн томоохон бүрэлдэхүүнийг хадгалахад оршино.

“Эрхэм зорилго”

Үндэсний түүх, угсаатны зүйн судалгааг тэргүүлэн явуулж, Монгол улсын түүхийн бүх үеийн тулгамдсан асуудлыг биет болон биет бус дурсгал, түүхийн эх сурвалжид тулгуурлан шинжлэх ухааны өндөр түвшинд цогц судлагааг эрхлэн гүйцэтгэдэг байгууллага мөн.

“Үнэт зүйл”

Монгол үндэстний оршин тогтнох аюулгүй байдлын дархлааг хамгаалж хөгжүүлэх, ард түмнийг соён гэгээрүүлж, дэлхийн түвшинд өрсөлдөх мэргэжилтнүүд бүрдүүлж, шударга, ил тод, бүтээлч үнэ цэнээ хадгалж, хүн төрөлхтөний соёл иргэншлийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэж, Монголын соёлыг хадгалах, хамгаалах, судлах, түгээх, өвлүүлэхэд оршино.

Хамрах цар хүрээ

Монгол нутагт хүн үүссэн цаг үеэс өнөөгийн ертөнцийг хүртэл оршин буй монголчуудын хүн төрөлхтөний түүхэнд гүйцэтгэсэн үүрэг байр суурийг тодорхойлох, Дотоод Азийн бүс нутагт Монгол улс төвтэй түүх, соёл иргэншлийн судалгааны төв болж оршино.

Стратеги төлөвлөгөөг ШУА-ийн Тэргүүлэгчдийн Газраас өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу ТУХ-ийн эрдэмтэн судлаачид, ажилтан албан хаагчид хамтран боловсруулав.

“ТУХ-ийн Стратеги төлөвлөгөө”-г боловсруулахдаа:

- Хүрээлэнгийн түүхэн хөгжил
- Хүрээлэнгийн чиг үүрэг
- Хүрээлэнгийн үйл ажиллагааны өнөөдрийн төлөв байдал, боломж, ирээдүйн нөөц
- Шинжлэх ухааны салбарын төрийн бодлого, хууль, эрх зүйн орчны шинэчлэл ба ТУХ-ийн онцлог
- ТУХ-д хэрэгжүүлсэн төслүүд, үйл ажиллагаанд хийсэн шинжилгээ, цаашид хамтран ажиллах чиглэлүүд
- Монгол улсад түүх, угсаатны судлал, археологи, сурвалж судлалын чиглэлээр судалгаа явуулж буй чиглэлийн байгууллагуудын онцлогийг харгалзан үзэх

- Монголын түүхч, эрдэмтэн судлаачид, ажилтнуудын санал хүсэлт, үйл ажиллагааны хандлага байдлыг харгалзан авч явуулсан.

Энэхүү стратеги төлөвлөгөөнд Хүрээлэнгийн хөгжлийн түүхэн явц, түвшин, өнөөгийн төлөв байдалд дүн шинжилгээ хийж, цаашид хийгдэх судалгаа шинжилгээний ажлын цар хүрээ, алс хэтийн зорилт, төлөв байдлыг баримжаалж, түүнд хүрэх арга замуудыг шинжлэн тодорхойлов.

Стратеги төлөвлөгөөг үндсэндээ хоёр үе шаттай байх буюу эхний үе шат нь 2018 - 2021 он, хоёрдугаар үе шат нь 2022 - 2025 он хүрээнд тооцож боловсруулав.

Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хүрээлэнгийн дунд хугацааны буюу 4 жилийн хөгжлийн төлөвлөгөө, мөн жил бүрийн үр дүнгийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх бөгөөд эдгээр төлөвлөгөөний биелэлт, түүнд хийсэн дүн шинжилгээг үндэслэн стратеги төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах замаар түүнийг сайжруулан шинэчилж байх болно. Мөн энэ хугацаанд гарсан төрийн бодлого, төлөвлөгөө, явцын нөхцөл байдлаас үүсэх хөгжлийн чиг хандлагыг ч тооцож үзсэн байгаа. Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн үйл ажиллагааг өргөтгөж, салбар төвүүдийн шаардлагагүй хэсэгт өөрчлөлт оруулах, Монголын түүх хэмээх томоохон үндсэн чиглэлийн хүрээнд тогтвортой нөхцөл буй болгоход гол анхаарал хандуулна.

Энэхүү стратеги төлөвлөгөөний зорилтууд нь Монгол улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, салбарын яам, ШУА, ШУТС зэрэг байгууллагуудын төлөвлөгөөнд тусгагдан, бодит ажил хэрэг болоход дээрхи байгууллагууд бодлого, хэрэгжүүлэх зарчмын хувьд дэмжлэг үзүүлнэ хэмээн итгэж байна. Тэгсний үндсэн дээр Монголын түүх, угсаатны судлал, археологи, сурвалж бичгийн судалгааг өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулж, одоогийн төлөвлөсөнийг хэрэгжүүлэх, дараагийн үе шатыг тодорхойлох, хүн төрөлхтний соёл иргэншилд монголчуудын оруулсан хувь нэмрийг тодотгож, судалгааны хувьд олон улсын хэмжээнд хүрэх боломж бүрдэх билээ.

Захирал, Түүхийн шинжлэх ухааны доктор, академич

С.Чулуун

НЭГ. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, ЗАРЧИМ, АЧ ХОЛБОГДОЛ

- *Стратеги төлөвлөгөө боловсруулсан нийтлэг үндэслэл*
- *Стратеги төлөвлөгөө боловсруулсан үндсэн зарчмууд*

Монгол улсын Шинжлэх ухааны академийн Эрх зүйн байдлын тухай хууль, Шинжлэх ухаан технологийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоол, журмуудын нийтлэг шаардлагуудад нийцүүлэн төрөөс Шинжлэх ухаан технологийн талаар баримтлах бодлого, Монгол улсын Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөр, Монгол Улсын Засгийн Газрын мөрийн хөтөлбөр, ШУА-ийн ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөр, Монгол улсын Ерөнхийлөгчийн “Эх хэл, түүх, соёлоо судлах, хөгжүүлэх ажлыг дэмжих тухай” 162 –р зарлиг, ТУХ-ийн захирлын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэн хүрээлэнгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, судалгаа-сургалт-сурталчилгааны (ССС) бодлогыг боловсруулах, түүх, угсаатны судлал, археологи, сурвалж судлалын ирээдүйн чиг хандлага, хэрэгжүүлэх арга замын тодорхой цаг хугацаанд хөгжүүлэх шаардлага, өмнө өөрийн гэсэн бодлогогүй байсан тодорхой салбаруудыг системтэй хөгжүүлэх, алдааг засаж, амжилтыг бий болгох түүхэн нөхцөл шаардаж байна.

Өнгөрсөн-одоо-ирээдүй гурван цагийн холбоо, үнэт зүйлсүүд, нийгэмд үүсэж буй шаардлага дээр үндэслэн хүрээлэнгийн эрхэм зорилго, зорилт, үндсэн чиг үүргийг өргөтгөн тодорхойлох, дахин шинэчлэх, түүнд хүрэх арга замыг баримжаалах боломжтой, хэрэгжих нөхцөлтэй “стратегийн бодлого” (*Strategic policy*) боловсруулах шаардлага урган гарч, цаашид монголын шинжлэх ухааны салбар, түүний дотор салбарын хүрээлэнгүүдийн хувь заяаг илүү тодорхой болгож, нэгтгэн зангидаж, нэгдсэн бодлоготой, тодорхой баримтлах төлөвлөгөө, үндсэн эрх зүйн баримттай хөгжүүлэх нөхцөл үүссэн.

Энэхүү Стратеги төлөвлөгөөнд Хүрээлэнгийн үүсэл хөгжил, өнөөгийн төлөв байдалд дүн шинжилгээ хийж цаашид хүрээлэн дээр хийх судалгаа шинжилгээний ажлын цар хүрээ, алс хэтийн хараа төлөв байдлыг баримжаалж, түүнд хүрэх арга замуудыг тодорхойлон шинжлэхийг зорьсон болно.

Стратеги төлөвлөгөө боловсруулсан нийтлэг үндэслэл: Стратеги төлөвлөгөө боловсруулах ерөнхий үндэслэл нь үндсэн зарчмын агуулгыг багтаасан хэлбэртэй байна. Үүнд: мэргэжлийн онцлог байдал, өнөөгийн түвшин, олон улсад болон бүс нутагт хүргэх болон бүс нутагт хүргэх боломж, хөрш орнуудын улс төр, нийгэм, соёлын бодлоготой нягт уялдуулж, Монголын түүх, соёлын дархлааг баталгаажуулах, Тогтсон бодлогогүй явагдаж ирсэн археологи, угсаатны судалгааны үйл ажиллагааг зөвхөн Монгол улсын хэмжээнд биш бүс нутгийн гол төв болгон хөгжүүлэх, соёлын цар хүрээг тэлэх, Соёлын биет бүс өвийг судлах, судалгааны дэг сургуулийг буй болгож, технологи, инновацийн үндсэн чиглэлийг буй болгох, Соёлын өвийг малтан судлахаас илүүтэй хамгаалах, түүнийг олон түмэнд түгээх, сурталчлах, “археологи, угсаатны судлал”-ын цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэх зэрэг нийтлэг хэд хэдэн үндэслэлт мөн тулгуурлан авч үзсэн болно.

Стратеги төлөвлөгөө боловсруулсан үндсэн зарчим: ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнг 2018-2025 онуудад хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг дараах зарчим, шинэчлэл, өөрчлөлтийн чиг хандлага дээр үндэслэн боловсруулав.

Хүрээлэнгийн стратеги төлөвлөгөөг боловсруулахад баримталсан үндсэн зарчим нь:

- ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн өмнөх үеийн хийж хэрэгжүүлсэн тодорхой ажлуудад тулгуурлан, алдааг дэнслэн анхаарч, одоо үеийн үйл ажиллагаа, үнэт зүйлстэй бодитой дүгнэлт хийн, ирээдүйн хөгжлийн төлөв байдлаа бүс нутаг, олон улсын

түвшинд дөхүүлэх, тодорхой түвшинд хүргэх, өөрийн байр сууриа хадгалах, Монгол улсыг бүс нутгийн төв болгохдоо бодит нөхцөл байдал, Монголын болон бусад хамтрагч орны улс төр, эдийн засгийн боломжид баримжаалж тулгуурлан тодорхойлох,

- Хүрээлэнгийн үйл ажиллагааг өөрийн эх орны болон бүс нутаг, олон улсын харилцааны эрх ашиг, зорилгод нийцүүлэх,

- Хүрээлэнгийн судалгааны түвшинд тэргүүлэх чиглэлүүдээ тодорхой болгох, түүнд тохирсон бодлого, үйл ажиллагааг явуулах, өөрсдийн судалгааны одоогийн түвшинд дүн шинжилгээ хийх, тодорхойлох,

- Хүрээлэнгийн судалгаа, шинжилгээний үр дүнг төрийн болон төрийн бус байгууллагуудын хэрэгцээг хангах, нийгмийг соён гэгээрүүлэх, онцгойлон монголын түүхийн бүс нутагт хандах хандлагыг өөрчлөх, тодорхой чиглэлд тулгуурласан бодлого буй болгох,

- Судалгаа, шинжилгээний хэрэгжүүлж ирсэн болон хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, захиалгат ажлуудад дүгнэлт хийж, үр ашгийг үнэн зөв тооцох, дүн шинжилгээ хийх, хүрээлэнгийн сан хөмрөг, лаборторийг хэрхэн байлгаж байсан зэрэгт дүгнэлт хийлгэж, цаашид хэрхэх тухай Хүрээлэнгийн эрдмийн хамт олон болон Эрдмийн зөвлөл, мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх, өмнөх байдлыг мэдээлэлийн хэрэгсэлээр нийтлэх, өнөөгийн байдлыг танилцуулах, цаашдын төлөвлөгөөг боловсруулах,

- Стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ төсвийн хөрөнгийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, нэмэлт санхүүжилт буй болгох арга замуудыг төсөөлөх зэрэг үндсэн зарчмуудыг удирдлага болгоно.

ТУХ-ийн стратеги төлөвлөгөөний ач холбогдлыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Монгол улсад Түүхийн шинжлэх ухааны орчин үеийн эх суурь 1921 оноос тавигдаж, хөгжил, хувьслын олон үеийг туулан өнөөг хүрэхдээ Монголын шинжлэх ухааны байгууллагын гол хүрээлэнгүүдийн нэг болж чадсан бөгөөд эрчимтэй хөгжлийн үе нь 1950-иад оноос эхэлж, мэргэжлийн түвшинд судалгаа хийсэн судлаачдын нэгэн үеийг буй болгож, тодорхой дэг сургуулиуд үүсэж бүрэлдсэн билээ. Хөгжил хувьслын түүхэн үйл явцад тус хүрээлэнгээс нийгэм, хүмүүнлэгийн ухааны хэд хэдэн хүрээлэн төрөн гарсан түүхтэй. Ахмад үеийн өвлүүлсэн суурь дээр тулгуурлан өнөөгийн нөхцөлд боломж, бололцооныхоо хэрээр түүх, археологи, угсаатны судлал, сурвалж судлалын салбарыг тодорхой бодлогоор хөгжүүлэх ажил хийгдэж байна. 1990-ээд оны дараа угсаатан судлал зэрэг салбарт томоохон хямрал үүсэж, тодорхой алсыг чиглэсэн бодлоготой бус гадаадын улс орнуудын хүссэн заасан чиглэлээр ажиллаж, хар зөнгөөрөө хөгжиж ирсэн гашуун түүх ч бас буй. Харин сүүлийн үед Засгийн газраас хэрэгжүүлж эхэлсэн бодлого үйл ажиллагааны үр дүнд энэ замбараагүй байдал багасаж байгаа ч цаашид улам нарийн судлан шинжилж, нэгдсэн төвлөгөөтэй, нэгдмэл бодлоготой явуулах нь зайлшгүй шийдэгдэх асуудлын нэг юм. Гэвч өнгөрсөн цаг хугацаанд манай салбарын туулж ирсэн бүхий л түүхэн цаг хугацаа нь дэлхийн болон бүс нутгийн хэмжээнд түүхийн салбарыг тээж явах томоохон өв сан хөмрөг буй болж, дэг сургуулиуд үүссэн нь бидэнд нөөц боломж байна.

- Хүрээлэнгийн судалгаа шинжилгээний ажил нь түүхийн судалгаанаас гадна угсаатан судлал, нийгэм-соёлын хүн судлал нэлээд хөгжиж тодорхой мэдээлэлийн нэлээд өргөн хүрээтэй сан хөмрөгтэй болоод байгааг Монгол улсын нийгэм-эдийн засгийн хөгжил, сургалтын систем, олон түмнийг соён гэгээрүүлэх үйл хэрэгт зориулах боломж бүрдэнэ.

- Тус хүрээлэн нь өнөөдөр Монголын шинжлэх ухааны салбаруудаас хамгийн өргөн гадаад хамтын ажиллагаатай, тодорхой түвшинд ажилласан туршлага хуримтлуулаад байгаа бөгөөд дотоодын төр засгийн болон бодлогын салбарууд, төрийн бус байгууллага, иргэдтэй

нягт хамтран ажиллах ажиллагааг улам өргөжүүлнэ. Монгол төрийн оршин байх үндсэн дархлаа бол түүх, соёл гэж Үндэсний Аюулгүй байдлын заалтыг бодитойгоор хэрэгжүүлэх, Монгол улс Монгол судлалын төв байх үүргийг хадгалж явах үндэсний дархлааг тогтвортой нэвчүүлнэ.

- Хүрээлэнгийн судалгааны ажлыг нийгмийг соён гэгээрүүлэхэд чиглүүлэх, археологи, угсаатны өв соёлыг зөвхөн бизнес болгодог, малтан судлаж, эрэл хайгуул хийдэг олз хайгчийн ойлголттой системээс онол арга зүйн өндөр түвшинд судалгаа явуулдаг, бодлоготой, олдвор дурсгалыг хадгалах хамгаалах орчинтой болгохыг археологи, угсаатны зүйн салбарт хатуу баримтлан хөгжүүлнэ. Түүх, угсаатны салбарт сахилга хариуцлага, замбараагүй байдлыг бүрэн халж, системтэй бодлоготой, үр дүнтэй байдлыг төлөвшүүлж ажиллана.

- Хүрээлэн түүхийн судалгааны ном бүтээл, сурвалж баримт бичгийн хувьд Монголын төдийгүй дэлхийд тархсан монгол өвийн мэдээлэлийн хамгийн том цахим төв болох зорилтыг бүрэн хэрэгжүүлнэ.

- Хүрээлэнгийн судлаачдын мэдлэгийн түвшинг дээшлүүлэх, судалгаа хийсэн нь үр дүнгээ хүртдэг, судалгааны бүтээлд нэрээ тавьсан нь үлддэг зарчмыг баримтална. Гадаад олон улсад бэлтгэгдэж буй түүх, угсаатан судлалын чадвартай судлаач залуучуудыг ажлын байраар хангах, идэвхтэй ажиллах боломжийг бүрэн бүрдүүлэх, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх, орчин, тоног төхөөрөмжийг өнөөгийн судалгааны арга зүйн түвшингийн хэмжээнд ашиглах боломжоор хангаж өгнө.

Түүх, угсаатны зүйн салбарын бүх салбарт жигд мэргэжилтэй боловсон хүчинг бэлтгэж дуусгана. Тухайлбал, Евразийн нүүдэлчид, Монголын эртний улсын түүх, археологийн салбарыг боловсон хүчнээр хангах, эрдмийн зэрэг цол хамгаалуулахад дэмжлэг үзүүлнэ. Боловсон хүчний хувьд түүх, угсаатны салбар эхний шатны төлөвлөгөөгөө бүрэн давсан бөгөөд дараагийн шатанд олон улсад судалгаа хийх боломжийг тэдэнд олгож, дэлхийн нэр хүндтэй судалгааны төвүүдэд судлаачдыг ажиллуулах боломжийг бүрдүүлэх зэрэг нь Хүрээлэнгийн баримтлах бодлогын гол тулгуур үндэс, стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлснээс гарах үр ач холбогдол гэж үзэж байна.

ХОЁР. ХҮРЭЭЛЭНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1. Хүрээлэнгийн үүсэл, хөгжил

XX зууны Монголын түүхэнд хийгдсэн хамгийн чухал бүтээн байгуулалтын нэг бол шинжлэх ухааны өвийг монголчууд буй болгож чадсан явдал юм.

Анх 1921 оны 11 дүгээр сард Монголын бичгийн мэргэд, түшмэл Ж. Цэвээн зэрэг хүмүүс Богд Жибзундамбад “Бичиг судрын хүрээлэн” байгуулахыг мэдүүлсний хариуд “мэдэв” хэмээн зөвшөөрүүлснээр эрдэм судлалын анхны байгууллагын шанг татаж, бүтээн босгох их үйлс эхэлсэн билээ.

Судар бичгийн хүрээлэнгийн анхны зорилгын нэг нь Монголын түүхнээ холбогдох ном судрыг цуглуулах, судлах, түүхийн зохиол бүтээл туурвих явдал байж, үндсэн гол судалгаа нь монгол хэл бичиг, түүх, хүн ардын аж байдал (*ethnograph*)-ыг судлахад чиглэж иржээ. 1930 онд Судар бичгийн хүрээлэнг Шинжлэх Ухааны хүрээлэн болгон өргөтгөж бүтцийн өөрчлөлт хийсэн бөгөөд 1935 онд Түүхийн кабинетийг албан ёсоор байгуулан их зохиолч Д.Нацагдоржийг анхны даргаар нь тохоон томилсон байдаг. Улмаар Шинжлэх ухааны хүрээлэнгийн Тэргүүлэгчдийн 1941 оны 8 сарын 28-ны өдрийн хурлын 106 тоот

тогтоолоор Түүхийн кабинетийг өргөтгөн Түүхийн тасаг болгож, эрхлэгчид “жижиг” Нацаг буюу хожмын ШУА-ийн дэд ерөнхийлөгч, академич Ш.Нацагдоржийг томилжээ.

1940-өөд оноос түүхийг судалгааг марксист онол арга зүйгээр судлахыг төрөөс даалгаж, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэж эхэлсэнээр анхны түүхч, археологичид төрөн гарсан. 1961 онд БНМАУ-ын Шинжлэх ухааны Академи албан ёсоор байгуулагдахад анхны таван хүрээлэнгийн нэг Түүхийн хүрээлэн болж, археологи-этнограф, орчин үеийн түүх гэсэн хэдэн салбартайгаар үйл ажиллагаагаа эхэлсэн түүхтэй.

Тэр цагаас хойш Монгол улсын бүрэн түүхийг бичих, археологи-угсаатны судалгаа хийх ажлыг эрчимтэй өрнүүлж 1966-1968 онд анхны нэгдсэн боть БНМАУ-ын түүх, 1984 онд “БНМАУ-ын түүх” нэгэн боть, 1999-2002 онд “Монгол Улсын түүх” 5 боть бүтээлүүдийг туурвиж, “Монгол улсын угсаатны зүй” 3 ботийг 1987-1995 оны хооронд тус тус бүтээж, 2016 онд “Монголын археологийн өв” 7 боть бүтээл, Монгол улсын угсаатны судалгааны тайлан 10 боть, Монголын археологийн шинэ судалгаа, шинэ хандлага 3 боть бүтээлүүдийг хийж гүйцэтгээд байна.

2015 оны 2 сараас Түүх, Археологийн хүрээлэн, 2019 оны 9 сараас Түүх, Угсаатны зүйн хүрээлэн гэсэн нэрээр тасралтгүй эрдэм судлалын үйл ажиллагаагаа явуулж байна.

“Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол улсын Засгийн газрын 2019 оны 8 сарын 14-ний өдрийн 328 дугаар тогтоолын дагуу ШУА-д хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөр Түүх, угсаатны зүйн хүрээлэн нь 54 хүний орон тоотойгоор өөрчлөн байгуулагдаж, түүх, угсаатны судлал, сурвалж бичгийн судалгааны суурь судалгааг явуулж байна. Бидний ойрын үед хийгдэх томоохон төлөвлөгөөнд Монгол улсын түүх 25 боть, Дэлхийд тархсан Монголын өв 20 боть, Угсаатны судлалын судалгааны лаборатори, сурвалж бичгийн судалгааны сан хөмрөг буй болгох, туурвих ажил хийгдэж эхлээд байна. Ийнхүү Монгол улсад тогтвортой суурь судалгаа явуулах бүрэн түүх уламжлалтай, цаашид зөв бодлого, зөв стратеги боловсруулан ажиллах бололцоотой төдийгүй бүс нутаг, дэлхийн хэмжээнд судалгааны бүтээл хийж чадах боломжтой хүрээлэн болж чадсан байна.

2.1.1. Хүрээлэнгийн хөгжлийн төлөв байдал

Хүрээлэнгийн өнгөрсөн түүхийн байдлыг авч үзэхээс гадна ирээдүйд хөгжлийн төлөв хандлага нь ямар буйг дараахь байдлаар харуулахыг хичээв. Тус хүрээлэн нь суурь судалгааны чиглэлийн нийт 2 төв, 6 салбартай болно. Евразийн эртний нүүдэлчид, эртний улсуудын түүх, археологийн салбар, Монголын эзэнт гүрэн ба дундад үеийн түүхийн судалгааны салбар, Орчин үе, бүс нутгийн судалгааны салбар, Угсаатан судлал, нийгмийн хүн судлалын салбар, Хэрэглээний угсаатны судлал, биет бус соёлын өвийн төв, Сурвалж судлал, баримт мэдээлэлийн төв ба Академич Б.Ширэндэвийн дурсгалын танхим гэсэн бүтэцтэй үйл ажиллагаа явуулж байна.

Хүрээлэн нь 19 гишүүнтэй Эрдмийн зөвлөл, 11 гишүүнтэй Захирлын зөвлөлөөс бүрдэнэ. ҮЭ-ийн хороо буй. Албан бус Төв Ази ба Дотоод Азийн судалгааны Лейдений Ази, Африкийн хүрээлэнгийн салбар зөвлөл, Японы хүмүүнлэгийн Үндэсний хүрээлэн ШУА-ийн хооронд байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний дагуу нээсэн “Зүүн хойд Азийн судалгааны оффис”, БНСУ-ын Зүүн хойд Азийн сангийн дэмжлэгээр Солонгос-Монголын түүхч-археологчдийн холбоо, Монгол-Орос-Хятадын археологийн форум зэрэг төв, салбар, оффисүүд байрлана. Мөн Монголын түүхчдийн холбоо, Түүх, Археологиор шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалах зөвлөл, Монголын угсаатны судлалын холбоог тус хүрээлэнд төвлөн удирдаж байна. Өөрөөр хэлбэл, Монгол улсад болон бүс нутагтай харилцах гол судалгааны төвүүд энэ хүрээлэнгийн дэргэд байрлаж байгаа нь гол давуу талтай юм. Мөн тус

хүрээлэнгийн захирал, академич С.Чулуун Дэлхийн Монгол судлалын төв байгууллага Олон улсын Монгол судлалын Холбооны ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж байгаа болно.



Хүрээлэнгийн шинэ бүтэц, зохион байгуулалтыг ШУА-ийн Тэргүүлэгчдийн 2019 оны 10 сарын 03-ны өдрийн хурлын 07 тоот тогтоолын 7-р хавсралтаар баталсан болно. (Зураг 1).

2.1.2. Хүрээлэнгийн эрдэм судалгааны онол, арга зүйн түвшин

Тус хүрээлэнгийн судалгааны онол арга зүйн өнөөгийн түвшинг гол судалгааны үр дүн бүтээлүүдээр дүгнэх ёстой. 1950-1990 оны үед тус хүрээлэнгийн түүхийн судалгааны онол арга зүйн үндсэн чиглэл нь марксист онол, үзэл баримтлалд суурилсан судалгаа явуулахад оршиж байв. Тухайн үед манай ахмадууд нэг үзэл онолоор судалгаа явуулж байсан хэдий ч Монголын түүхийн судалгааны бүхэл бүтэн үеийг цогцоор нь авч үзэх арга зүйг хэрэглэж, үндэс суурийг тавьсан. Угсаатны судалгааны хувьд мөн дан ганц зөвлөлтийн дэг сургуулиар хөгжиж 1990-ээд онтой золгосон бөгөөд, 1990-ээд оноос хойш дэлхийн нэлээд орны өндөр хөгжилтэй орнуудын арга зүйн хандлага орж ирсэн боловч бодит өөрчлөлт гараагүй байсан юм. Харин сүүлийн жилүүдэд тус салбараас Польш, Унгар, БНХАУ, ОХУ зэрэг газруудад суралцаж судалгааны шинэ хандлага, арга зүй суралцсан учир нэлээд өөрчлөлт орж байгаа болно. Гэхдээ өнөөг хүртэл судалгааны чиглэлүүд системтэй биш учир олон улсын өндөр зэрэглэлийн судалгаанд хүрэх нэгдсэн лаборатори байхгүй, судалгааны бааз сан хөмрөг байхгүй, мэргэжлийн түвшинд бэлтгэж боловсруулсан төлөвлөгөө байхгүй, үзэл баримтлал, онолын дэг сургууль байхгүй байгаа нь хөгжлийн өнөөгийн төвшнөөс ихээхэн хоцрогдсон явааг харуулж байна. Харин Монгол улс нүүдлийн амьдралын сонгодог хэв маягыг хадгалж үлдсэн, амьдралын өвөрмөц хэв маяг бүхий ард түмэн учир өөрөө баялаг судалгааны судлагдахууны нөөц ихтэй учир биет бус өвийн тодорхой мэдээлэл, хамтын судалгаа ямар нэгэн хэмжээнд явсаар ирсэн бас боломж хангалттай байсан. Түүнээс удирдлагын хувьд ч судлаачдын хувьд олон улсын эрдэмтдийн хөтчийн үүрэг гүйцэтгэсээр өнөөг хүрсэн нь цаашид тэргүүлэн удирдах хэмжээний судалгаанд ойртуулах шаардлага гарсаар байгаа юм.

Арга зүйн хувьд залуучууд уламжлалт нийгмийг судлах арга зүйг хэрэглэж байгаа бөгөөд орчин үеийн судалгааны арга зүй, хээрийн болон суурин судалгааны лабораторийн орчин нөхцөл өнөөг хүртэл бүрдээгүй байна. Гэвч угсаатны судлалын хувьд судалгааны арга зүй хандлага өөрчлөгдөж, сүүлийн жилүүдэд явуулсан үр дүнгийн хувьд олон улсын нэр хүндтэй их дээд сургуулийн дэг сургуулиас суралцаж, нэгэн үеийн өрнөдийн нийгэм, соёл (*social and culture antropology*)-ын, оросын угсаатны судлалын (*ethnology*), дорно дахины уламжлалт арга зүйг эзэмшиж, судалгааны шинэлэг аргуудыг ашиглах боломж бүрдээд байгаа нь сайшаалтай. Аман түүхийн судалгаа, нийгмийн өөрчлөлтийн судалгаа, биет бус соёлын өвийн судалгаа, социологийн судалгааг судалгааны түвшинд ашиглаж нэр хүндтэй сэтгүүлүүдэд өгүүлэлүүд нийтлэгдэж эхлэх боломж бүрдсэн гэж үзэж байна.

Түүхийн баримтыг судлах, мэдээллийг хөгжүүлэх үйл ажиллагаа идэвхжиж дотоодын болон дэлхийн 10 гаруй орны архив, номын сан, музей, хувь хүмүүсийн сан хөмрөгөөс монголын түүхийн холбоотой эд өлгийн зүйлс, түүхийн баримт, архивын данс хараа, бусад хэрэглэгдэхүүнд тулгуурласан үйл ажиллагааг явуулж буй дэлхийн монгол судлалын томоохон төв гэж хэлж болно. БНХАУ, Англи зэрэг оронд ийм хэмжээний төсөл хэрэгжүүлсэн боловч тус хүрээлэнгийн сан хөмрөгт буй баримтууд нь тэдний сан хөмрөгт хамрагдаагүй дурсгалууд болно. Өөрөөр хэлбэл орчин үеийн цахим мэдээлэл нэгдсэн сан (*database*) буй болгож, дэлхийн монгол судлал, Монголын өв соёлын талаар нээлттэй мэдээлэл авах арга зүйг хангаж чадаж байгаа бөгөөд цаашид бид цөөн хэдэн орноос хамааралтай дурсгалуудыг авснаар энэ төсөл дуусаж Монголын түүхийн нэгдсэн сан хөмрөг байгуулагдах боломжтой. Уг сан хөмрөгийг олон улсын стандартад хүргэж дэлхийд нээлттэй болгох нь бидний нэг гол зорилт болно.

Тус хүрээлэнд явагдаж буй археологийн судалгаа нь нэлээд хязгаарлагдмал тодорхой хэдэн чиглэлээр хийгддэг учир судалгааны цар хүрээг өргөтгөх, хөгжүүлэхэд энэ чиглэлийн судалгааг тулгуур болгон явуулж буй Археологийн хүрээлэн, Үндэсний музей зэрэгтэй хамтран томоохон хэмжээний үндэсний болон олон улсын төсөл зохион байгуулах, хамтран ажиллах замаар Евразийн эртний нүүдэлчдийн түүх болон Монголын эртний улсуудын түүхийн судалгааг цогцоор нь судална. Мөн Монголын эзэнт гүрний дараахь үеийн хот суурины цогц археологийн судалгааг явуулж нэгдсэн сан хөмрөг байгуулна.

Цаашид стратеги төлөвлөгөөний туршид бүрэн гүйцэтгэж Монгол төдийгүй дэлхийн судлаачид Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн хийсэн биет бус өвийн бүрэн мэдээлэлийн санг нээлттэй ашиглах боломж бүрдэнэ.

Орчин үе бүс нутгийн салбарын хувьд Монголын түүхийг судлах арга зүй, зарчимдаа өөрчлөлт оруулж, Монголын түүхийг судлах явдлыг орон зайг өргөтгөх, Монгол болон хөрш орнуудад буй монгол туургатны хүрээнд судалгаа явуулах, энэ чиглэлийн мэргэжилтэнг эдгээр орнуудад суралцсан боловсон хүчнээр хангаж, шинэ арга зүй хандлагаар Монголын түүхийг авч судалж байна. Судалгааны арга зүй, онолын чиг, үзэл баримтлал (*pradgima*) эрс өөр болж байгаа нь нэгэн шинэ боломж болно.

2.1.3. Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний үйл ажиллагааны орц, гарцын шинжилгээ

Тус хүрээлэнгийн судлаачид болон ажилчдын Монгол улсын Засгийн газраас тогтоосон бүтцээр 54 орон тоотой бөгөөд, үүнд сэдэвт ажил, төсөл хөтөлбөр дээр гэрээгээр ажиллаж буй 10 орон тоо багтана. Үүнээс удирдах ажилтан 1, эрдэм шинжилгээний ажилтан 43, захиргаа, аж ахуйн ажилтан 10 болно.

Эрдэм шинжилгээний ажилтнуудаас академич 2, шинжлэх ухааны доктор 3, түүхийн ухааны (Ph.D) 20, магистр 15 байна. Жилд дунджаар 918,900,000 төгрөгийн санхүүжилттэй. Үүнээс ажилчдын цалин хөлсөнд 644,425, 488 төгрөгийг зарцуулж байна. Үүнд:

1. Евразийн эртний нүүдэлчид, эртний төрт улсын түүх, археологийн салбар нийт 6 ажилтантай. Жилд дунджаар цалинд 50,740,400 төгрөг, эрдэм шинжилгээнд 16,000,000 төгрөг зарцуулдаг. *Суурь судалгааны төсөлт ажил 1; Монгол, Оросын хамтарсан төсөл –1-тэй.*

2. Монголын эзэнт гүрэн ба дундад үеийн түүхийн судалгааны салбар 7 ажилтантай. Жилд дунджаар цалинд 69,040,600 төгрөг, эрдэм шинжилгээнд Захиалгат төслийн ажлын хөлс- 42,500,000 төгрөг зарцуулдаг. *Захиалгат төсөл 1;*

3. Орчин үе, бүс нутгийн судалгааны салбар 9 ажилтантай. Жилд дунджаар цалинд 137, 457,700 төгрөг, эрдэм шинжилгээнд 33,800,000 төгрөг зарцуулдаг. *Суурь судалгааны төсөлт ажил- 2; Монгол, Оросын хамтарсан төсөл 1-тэй.*

4. Угсаатан судлал, нийгмийн хүн судлалын салбар 7 ажилтантай, Жилд дунджаар цалинд 57,820,400 төгрөг, эрдэм шинжилгээнд 11,733,300 төгрөг зарцуулдаг. *Суурь судалгааны 1 төсөлт ажилтай;*

5. Хэрэглээний угсаатны судлал, биет бус соёлын өвийн төв 8 ажилтантай. Жилд дунджаар цалинд 94,449,800 төгрөг, эрдэм шинжилгээнд 12,666,600 төгрөг зарцуулдаг. *Суурь судалгааны 1 төсөлт ажилтай;*

6. Сурвалж судлал, баримт мэдээллийн төв 6 ажилтантай. Жилд дунджаар цалинд 117,152,100 төгрөг, эрдэм шинжилгээнд 9,405,000 төгрөг зарцуулдаг. *Суурь судалгааны 1 төсөлт ажилтай болно.*

ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн хөгжлийн стратегийн нэг гол орчин нь хүний нөөцийн (*human resources*) орчин болно. Тус хүрээлэнгийн судалгаа шинжилгээний стратеги төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэхэд хүний нөөцийн судалгааг чухал тулгуур гэж үзнэ. Хүний нөөцийг мэдлэг-мэдээлэл, судалгааны материалын боломж, санхүүгийн чадамж, эрэлт хэрэгцээнд тулгуурлах болно. Өөрөөр хэлбэл судлаачийн чадамж-судалгааны чиглэл-судалгааны үр дүнгээр хүний нөөцийн орчинг онцгой анхаарч авч үзэж байх болно.

2.1.4. Хүрээлэнгийн үйл ажиллагааны SWOT шинжилгээ

Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний хээрийн судалгааны үйл ажиллагаанд хийсэн SWOT шинжилгээний дүнд дараахь нөхцөл байдлыг тэмдэглэж байна.

Давуу тал:

Монголын түүх, угсаатан судлал, археологи нь нийгмийн шинжлэх ухаан, монгол судлалын уламжлалт, тэргүүлэх салбарын байр сууриа хадгалж буй бөгөөд цаашид хадгалж чадах бүрэн нөөц боломжтой;

Монголын түүх, угсаатны судалгааны дэг сургуулийг тодорхой хэмжээнд эхлүүлж чадсан нь салбарын гадаад, дотоодын эрдэмтэд төдийгүй олон нийтэд танигдсан, Монголын угсаатны судлалын судалгаа явуулах хамгийн давуу эрхийг эдэлдэг, судлаачдын 70 хувийг багтаасан багтай;

Түүх, угсаатны зүйн судалгааны хангалттай өв, төрөлжсөн мэдээллийн сан хөмрөг хийх боломж бүрдсэн, дэлхий дахинд тархсан Монголын соёлын өвийг хуулбарлах, судалгааны эргэлтэд оруулах, түүх, соёлын судалгааг эрчимтэй урагшлуулах нөхцөл бүрдүүлж, Монголын соёлын өвийн биет болон биет бус чиглэлээр дагнан ажилладаг залуу чадварлаг судлаачид бүрдсэн;

Түүх, угсаатан судлал, археологийн салбарын эрдэмтдийн гүйцэтгэсэн суурь болон хавсарга судалгааны үр дүн нийт энэ 20 гаран жилд нэлээд хуримтлагдаж, тодорхой судалгааны бараг бүх чиглэлээр эхний суурь судалгааг бусад их дээд сургууль, хүрээлэнгүүдтэй хамтран явуулсан туршлагатай;

Хүрээлэнг түүхч, угсаатны судлаач, археологич, сурвалж судлаач зэрэг мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, олон хэлний сурвалжуудыг эх хэлнээс нь уншиж ашиглах чадвартай судалгааны баг бүрэлдэж, Монголын түүхийн эх сурвалжийг цаашид үндсэн эх сурвалжаас унших, өрнө дорнын дэг сургуулийн төлөөлөл бүрэн хангагдсан залуу эрдэмтдийн нэгэн үе буй болж буйгаа эрдэм шинжилгээний ажилтнуудын дундаж нас 43 байна. Энэ нь бидэнд ихээхэн ирээдүй нөөц байна гэсэн үг;

Монголын эртний болон Эзэнт гүрний дараах үеийн хот суурины археологийн судалгааны үр дүнд илэрсэн соёлын баялаг сан хөмрөг, түүнийг олон түмэнд түгээн таниулах, дэлхий дахинд томоохон үзэсгэлэн бие даан зохион байгуулах хамтын ажиллагаатай, үндэсний хэмжээний соён гэгээрлийн болон соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжийг бүрдүүлсэн;

Угсаатны судлалын судалгааг дагнан явуулах боловсон хүчний нөөц, үе үеийн судлаачдын төлөөлөлтэйгээс гадна Монгол улсад цорын ганц угсаатны хээрийн судалгааны болон суурин судалгаа хийх нөөцтэй;

Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүсэд угсаатны буюу биет бус өвийн үндэсний музей байгуулах зөвшөөрлөө авах, судалгааны үзэл баримтлалаа боловсруулахаас гадна бүсчилсэн судалгааны төвүүдийг (*зүүн бүсийн судалгааны төв Хэнтий, Төвийн бүсийн судалгааны төв Орхоны хөндий, Өмнөд бүсийн судалгааны төв Дундговь, Умард бүсийн судалгааны төв Хөвсгөл*) байгуулж түүх, соёлын аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх боломж туршлага бүрэн боломжтой;

Сул тал:

Суурь судалгааг санхүүжүүлэх арга барил салбарын яамны талд хязгаарлагдмал, олгогдох эрдэм шинжилгээний зардал бага, хээрийн судалгааны орчин нөхцөлд хүрэлцээтэй бус, судлаачдын томилолт хангалттай бус;

Оюуны хөдөлмөр, ялангуяа нийгмийн ухааны салбарын судалгааны ажлын үнэлгээ маш доогуур, сургалтын үйл ажиллагаа явуулах боломж багатай, их дээд сургуулиудаас магистр, докторын сургалтыг удирдах боломж бага олгодог нь профессорын зэрэг, олон улсын сургалтын байгууллагад ажиллахад сөргөөр нөлөөлдөг;

Археологи, угсаатны хээрийн шинжилгээний зардал их төлөв гадаад хамтын ажиллагааны хүрээнд шийдэгдэх эсвэл авран хамгаалах судалгааны хүрээнд хийгдэж байгаа нь нэлээд хязгаарлагдмал шинжтэй явагдаж, тогтвортой суурин судалгааг явуулахад төвөг учруулдаг;

Хүрээлэнгийн салбар, төвийн судлаачдын чанар чинсаа харилцан адилгүй, зөвхөн авран хамгаалах эсвэл малтлагын ажил хийж, судалгааны суурин ажлыг хийхгүй, зардал мөнгөний төлөө мэт ажиллаж, судалгааны хувьд залуу судлаачдаа огт ахиулах хүсэлгүй байдал ажиглагдаж бөгөөд малтлагын дараа олдворуудаа сэргээн засварлах, хадгалах хамгаалах, бүртгүүлэх, мэдээлэх, угсаатны биет бус өвийн лабораторид хүлээлгэн өгөх ажил нэн хойрго хэвшмэл ойлголт болсон, ахлах судлаачид зөвхөн нэг улсын тодорхой нэг багийг чиглэлийн биш байсан ч хамтран ажиллаж, хөтчийн үүрэг гүйцэтгэж, өөр ямар нэгэн хүмүүсийг багтаан ажиллуулахгүй, санхүүжилт нь улсын байгууллагаар дамжидгүй хэвшмэл мэт ойлголт зарим салбарт тогтсон;

Хүрээлэнгийн лабораторийн орчныг сайжруулах, зориулалтын бус нөхцлөөс гаргах боломжийг хангах, мэргэжлийн түвшингийн судлаачдыг ажиллуулдаггүй, тооллого, хосгүй үнэт олдворын хяналт муу зэргээс гадна тус хүрээлэнгийн шинэ бүтэц байгуулагдахад хүчээр эрдэм шинжилгээний орон тоонд нийлүүлсэн ШУА-ийн нэгдсэн номын сан цаашид үйл ажиллагаа явуулах зардал боломжгүй, ажилчид нь судлаачдын орон тоог хааж байдаг зэрэг дотоод хүндхэн асуудлууд нэлээд буй;

Гадаад орнуудын архив, номын сангаас материал авах боломж хангалттай байгаа ч судлаачид зорьж явахыг боддоггүй, археологийн дурсгалуудын нөхцөл сайжруулах боломжийг эрэлхийлэх бус нэмж малтлага явуулах нөхцөлийг төсөөлөх судлаачдын байдал хүрээлэнгийн үйл ажиллагааны сул тал болоод байна. Гэвч энэ асуудлуудыг сүүлийн үед бодлогоор шийдвэрлэх алхмууд хийгдэж байгаа болно.

Боломж (*Opportunities*)

Хүрээлэнгийн давуу болон сул тал, хөгжлийн чиг хандлагыг нягтлан үзэж дүгнэлт хийхэд бидэнд дараахь боломжууд буй болж байгаа юм. Тус хүрээлэнгийн судалгаа шинжилгээний гол чиглэл нь онолын суурь судалгаа байдаг. Онолын суурь судалгааны дээрх чиглэлүүдээр хийж буй эрдэм шинжилгээний ажлын үр дүн нь судалгааны ажлын хүрээнд хуримтлагдсан мэдээллийн сан, боловсруулалтын үр дүнгүүд нь Монголын болон бүс нутаг, дэлхийн шинжлэх ухаанд Монголын эрдэмтдийн оруулж буй үнэтэй хувь нэмэр юм.

Өнөөдрийг хүртэл манай үе, үеийн эрдэм шинжилгээний ажилтнуудын бий болгосон судалгаа шинжилгээний материалууд, туурвисан эрдэм шинжилгээний бүтээлүүд нь Монгол нутагт хүн үүссэн цаг үеэс өнөөгийн Монголын нийгмийн бүхий л үзэгдлийг багтаасан он дараалалын дагуу, Монгол болон бүс нутгийн ай савд явагдсан түүхийн аливаа үйл явц, түүний зүй тогтол, нүүдлийн ертөнцийн онцлог, хүн төрөлхтний түүхэнд монголчуудын эзлэх байр суурь, гүйцэтгэсэн үүрэг, үлдээж хоцроосон өв соёлыг танин мэдэх, учир шалтгааныг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тайлбарлахын тулд хойч ирээдүйн судлаачдын хийж бүтээх судалгааны ажлын суурь, гараа нь болж байдгаараа онцлогтой. Өөрөөр хэлбэл, судалгааны ажлын үр дүнд бий болсон бүтээгдэхүүнийг хэрэглэх гол хэрэглэгчид нь судлаачид бид өөрсдөө, мөн түүнчлэн тухайн чиглэлээр судалгааны ажил явуулдаг дотоод, гадаадын эрдэм шинжилгээний байгууллагууд, эрдэмтэд, Монголын төр засгийн байгууллагууд болж байдаг.

- Монгол улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлалд Монгол улсын оршин байх дархлаа бол түүх, соёл, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2016 оны 162 дугаар зарлигаар эх хэл, түүх соёлыг дэмжих зарлигт түүх судлалын гол судалгааг Түүх, археологийн хүрээлэн явуулна гэж тодорхой заасан, Монгол улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөр, ШУА-ийн Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөр түүх, соёлын судалгааг онцгойлон дэмжих тухай эрх зүйн орчин маш сайн бүрэлдсэн.

- Одоогоор Монгол улсын Их хурлын Аюулгүй байдлын байнгын хорооны ажлын хэсэг, Монгол улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, Монгол улсын Засгийн газар, Нийслэлийн засаг Даргын Тамгын газар нь түүх, соёлын өвийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох асуудлыг онцгойлон дэмжиж тус хүрээлэнтэй хамтран ажиллах гэрээ байгуулан хэд хэдэн төслийг дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэгдэж байна.

- Угсаатны биет бус соёлын өвийн судалгаанд суурилсан технологи, инновацийн гарааны компани байгуулах, аялал жуулчлалын томоохон бүсүүдэд соёлын биет бус өвийн судалгаа-танин мэдэхүйн төвүүдийг байгуулах боломжтой.

- Бүс нутгийн болон олон улсын нэр хүнд бүхий 20 орчим улсын 40 орчим байгууллагатай хамтран ажиллах, Монголын талаас давуу эрхтэй ажиллах, судалгааны орчинг сайжруулах, судлаачдыг бэлтгэх, олдворын сэргээн засварлалт болон олон улсын хэмжээний үзэсгэлэнг зохион байгуулахаар гэрээ байгуулан ажиллаж байна.

Бидний хамтын судалгааны үр дүнд 2018 онд БНСУ-ын Үндэсний музейд “Тал нутгийн эзэнт гүрэн” үзэсгэлэн, 2019 оноос Японы зарим газруудад, 2019 оны төгсгөлөөс Турк, Унгар зэрэг нүүдэлчин гаралтай улсуудад зохион байгуулахаар эхний шатны ажлууд хэрэгжиж байна. Мөн дэлхийн нэр хүндтэй тэргүүлэх музей, номын сангуудад хадгалагдаж буй Монголын түүхтэй холбоотой архивын болон эд өлгийн зүйлсийг хамтран судлах,

Монгол болон тухайн оронд үзэсгэлэн гаргах, каталоги хийх гэрээ хэлэлцээр хийгдэн Тайваны хааны ордоны сан хөмрөгөөс 3 боть бүтээл, Эрмитаж Улсын музейтай 3 боть бүтээл, Английн Хааны Газарзүйн нийгэмлэг, Туркийн үндэсний номын сан, Ираны Архив, Польшийн Краковын архив, Оросын Газарзүйн нийгэмлэгийн архив, БНХАУ-ын Хааны 1-р архивууд нэгэнт ажлуудаа эхлүүлж байгаа нь бидний ажлын цар хүрээнд томоохон боломж олгож байгаа юм.

- Мэдээлэлийн нэгдсэн сан байгуулах, хүрээлэнгийн баримтын сан хөмрөгийг дэлхий дахинд нээлттэй танилцуулах, дэлхий дахинд тархсан Монголчуудын тухай гэрэл зургийн санг байгуулах ажлыг ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар, Японы Хүмүүнлэгийн Үндэсний хүрээлэнтэй хамтран 2020 гэхэд Монгол улсад бүрэн шилжүүлж өгөх бөгөөд бүрэн санхүүжилтийг Японы сангаас үзүүлж эхлээд байна.

- Мөн Монгол Угсаатны Үндэсний музей байгуулах ажил огт хөөцөлдсөн эзэнгүй, биелүүлсэн бүтээлгүй байсан бол Олон улсын нисэх буудал, Майдар төсөл, Богд хан уулын бүсэд археологийн музейн жишгээр тодорхой газрыг сонгон биет бус өвийг сурталчлах, танин мэдэхүйн төвийг буй болгож, ЮНЕСКО-гийн өвд бүртгэгдсэн биет бус өвүүдийг тусгайлан сурталчилсан төв, бүсчилсэн төвүүд зэргийн олон үйл ажиллагааг өрнүүлэх таатай нөхцөл бүрдээд байна. Эдгээр боломж нь бидний төлөвлөсөн стратеги төлөвлөгөөний хэрэгжих гол үүд нь болж чадна гэдэгт итгэлтэй байна.

Эрсдэл (*Threats*)

Бид бүхэн стратеги төлөвлөгөөний хүрээнд тавигдсан давуу тал боломжийг тооцохдоо үүсэж болох эрсдэлийг сайтар анхаарч болгоомжтой хандаж байна. Юуны өмнө, төрөөс шинжлэх ухааны талаар явуулах бодлого үйл ажиллагаа, санхүүжилт тогтвортой, хүрэлцээтэй байх эсэх, томоохон бүтээн байгуулалтын асуудлыг төрөөс дэмжлэг үзүүлэхгүй байх, хөрөнгө оруулахгүй байх эрсдэл үүсэх магадлалтай.

Гадаад орноос хандив тусламжийн шугамаар Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн салбарт ирж буй багаж тоног төхөөрөмж, судалгаа шинжилгээний бусад материалуудыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-аас чөлөөлөх асуудал хүндрэлтэй, бизнесийн болон ТББ-аас судалгаа шинжилгээний ажилд зарцуулсан хөрөнгийг татвараас хөнгөлөх, эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургууль, төрийн бус болон бизнесийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг зохицуулсан, хөхүүлэн дэмжсэн бодлого зохицуулалтын асуудал хангалтгүй.

Судалгаа шинжилгээний ажилд ашиглагддаг зарим тоног төхөөрөмж, материаллаг бааз хуучирсан, зориулалтын бус нөхцөлтэй сэргээн засварлах, дурсгалуудыг нарийвчлан судлах судалгааны чиглэлээр судалгааны багаж төхөөрөмжийг худалдан авах, шинэчлэх хөрөнгө оруулалт хангалттай хийгдээгүй.

Хөгжингүй орнуудад сурч байгаа болон эрдэм шинжилгээний ажил хийж буй залуу мэргэжилтэн, судлаачид ажлын байр, амьдралын баталгаа байхгүйн улмаас эх орондоо буцаж ирээд ажиллах сонирхол бага байна. Чадварлаг залуу ажилтан дан ганц төсвийн цалингаар эрдэм шинжилгээний байгууллагад ажиллах онц сонирхол байхгүй, боломж ч байхгүй зэргээс үүдэн шинжлэх ухааныг цаашид авч явах залуу халааг жинхэнэ утгаар бэлтгэх ирээдүй бүрхэг. Магистрт суралцуулах асуудлыг салбарын яамдад хариуцуулснаас яамны аппаратад ажилладаг залуус гадаадын магистрантурт суралцаж эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэх тогтолцоонд сөргөөр нөлөөлөх хандлага үүсэж болзошгүй.

2.1.5. Хүрээлэнгийн хөгжлийн төлөв байдал: ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг хангахын тулд дараах стратегийн ерөнхий төлөвийг харж зорилтуудаа салбар, төв бүрээр дэвшүүлж байна.

- Бүс нутгийн болон дэлхийн хэмжээнд явагдаж буй түүх, соёлын судалгааны түвшинд түүх, соёлын судалгааг явуулж, тухайн улс орнуудын түүх, соёлын талаарх судалгааны түвшинд өөрийн орны түвшинг хүргэх, судалгааны хувьд байнга идэвхтэй байх суурьтай оролцох;

- Түүх, соёлын талаар төрөөс явуулах бодлого үйл ажиллагаанд анхаарал тавьж, аливаа асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй судалж, энэ чиглэлээр төрөөс явуулж буй бодлого, үйл ажиллагаанд санал зөвлөмж өгөх, нийгмийн соён гэгээрүүлэх, өв соёлыг дотоод, гадаадад сурталчлах, танин мэдүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

- Түүх, угсаатны судлал, археологи, сурвалж судлалын суурь судалгааг явуулж, их, дээд сургууль болон дунд сургуулийн сурах бичиг, сургалтын үйл ажиллагааг мэдээллээр хангах, зөвлөгөө санамж өгөх, түүхийн сурах бичгийн хангалтгүй байдалд шүүмж дүгнэлт өгч, гадаадын улс орнуудад зааж буй сургалтын системд Монголын тухай хэрхэн үзэж байгаа асуудлыг байнга анхаарч, санал зөвлөмжөө хүргүүлж байх;

- Түүх, угсаатны судлал, археологи, сурвалж судлалын судалгааны хязгаарыг тогтоох, бүс нутагт өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, тэргүүлэх хэмжээнд судалгааг явуулах, Дотоод Ази (*Inner Asia*) судалгааны гол төв болох, Зүүн хойд Азийн бүс нутгийн түүх, соёлын судалгаанд идэвхтэй оролцох, Төв Азийн бүс нутгийн улсуудад буй Монголын түүхийн өв соёлын хамтран судлах;

- Биет бус өвийн цогц судалгааг явуулж бүс нутаг болон бусад нүүдэлчин ард түмний өв соёлтой харьцуулан судлах, Монголын өвөрмөц иргэншил, амьдралын хэв маяг, дүр төрх, дархлааг үндэсний болон олон улсын хамтын судалгааны үр дүнд өргөжүүлэн хөгжүүлэх;

- Түүхийн судалгааг дотоод, гадаадын монгол судлаачдын хувьд нээлттэй болгох, судалгааны эх материал, архивын баримт, гар бичмэлийг судлах, хамгаалах боломжийг хангаж Нэгдсэн мэдээллийн сан (*database*) байгуулах, нээлттэй хүрээлэн байгуулах ажлыг бүрэн хэрэгжүүлэх, археологи, угсаатны судлалын судалгаа явуулахын зэрэгцээ илэрч олдсон дурсгалуудаар олон төрлийн хуулбар, 3D зэрэг хэрэгслийг ашиглаж соёлын бүтээлч үйлдвэрлэл, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгоход судалгааны арга зүйгээр хангах, Монголын угсаатны судалгааг цогцоор нь явуулж, биет бус өвийн судалгааг явуулж, судалгааны нэгдсэн сан хөмрөг үүсгэж, соёлын биет бус өвийн завсардсан цогц судалгааг явуулах, холбогдох мэргэжлийн байгууллагуудад зөвлөгөө өгөх;

- Боловсон хүчний талаар шаталсан цаг хугацааны мэргэжилтэнг системтэй бэлтгэх, монгол судлалын тулгуур төвүүдэд сургах, ажиллуулах, эрдэм шинжилгээний болон ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэрэг төлөв байдлыг багтааж харж байна.

ГУРАВ. ХҮРЭЭЛЭНГИЙН СТРАТЕГИ ЗОРИЛТУУД (2018-2025)

I. Монгол Улсад түүх, угсаатны судлалын чиглэлээр тэргүүлэн манлайлсан, олон улс болон бүс нутгийн хэмжээний түвшинд судалгааг нэр хүндтэй явуулахад идэвхтэй, системтэй, алсын хараатай хамтран ажиллана.

II. Нийгмийг соён гэгээрүүлэх, улс орны төрийн бодлого, үндэсний дархлаа, оршин байхын үндсийг баталгаажуулан, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулна.

III. Дотоод, гадаадын хамтын ажиллагаагаа одоогийн байгаа түвшингээс урагшлуулан тооноос чанарт шилжүүлж, Монгол улсын өв, соёлыг хүндэтгэн үзэгч, өөрийн улс орондоо нэр хүндтэй байгууллага, их дээд сургууль, судалгааны төвүүдтэй идэвхтэй хамтран үр дүнтэй ажиллаж, дэлхийн монгол судлалын судалгааны байгууллага, хувь судлаачидтай харилцаагаа өргөжүүлнэ.

IV. Орчин үеийн судалгааны лабораторийг буй болгох, Монгол улсад бүсчилсэн судалгааны төв, музейг байгуулах ажлыг эрчимжүүлнэ. Монголын Үндэсний Угсаатны музейг байгуулахыг зорино.

V. Шинжлэх ухаан, шинэ мэдлэгийг эрхэм болгож, судлаачдын ёс зүйг чанд сахисан, эрдэм судлалын байгууллагад тууштай ажиллах чадварлаг судлаачдаар эгнээгээ өргөтгөн, ажилтан, албан хаагчдын ажиллах, амьдрах бүхий л талын таатай орчин нөхцлийг цогцлон бүрдүүлсэн эрдэм шинжилгээний жишиг байгууллага болно.

3.1. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах судалгаа боловсруулалтын зорилт

а) Евразийн эртний нүүдэлчид, эртний төрт улсын түүх, археологийн судалгааны салбарын зорилт: Монгол нутагт амьдарч өвөг Монголчуудын угсаа гарал, угсаатны хөгжлийн явцыг археологи, антропологи, генетикийн судалгаагаар нарийвчлан тогтоох, нийгэм-аж ахуй, соёл, шашин шүтлэгийн цогцолбор судалгааг Евразийн хүрэл-төмрийн үеийн соёл иргэншлийн суурь дээр үндэслэж Монголын онцлогийг тодорхойлох, мал аж ахуйн үүсэл, хөгжил, нүүдлийн болон суурин иргэншлийн харилцааны хөгжил, энэ үеийн соёлын биет дурсгалуудын хөгжлийн үндсэн зүй тогтлыг илрүүлэн судлах, нас тогтоох шинжилгээг хийх, радиокарбон, рентген-изотоп, газарзүйн мэдээллийн системийн үр дүнг нэгтгэн судлана.

Мөн бүс нутгийн хэмжээнд Монголын эртний түүхийг тавьж Евразийн бүс нутаг дахь нүүдэлчид хэмээх томоохон орон зайд харж, өөрийн өвөг дээдсийн түүхэн хөгжил, бүс нутгийн хэмжээнд үзүүлэх нөлөө байр суурийг тодорхойлж гаргах нь чухал байна. Мөн Монголын анхны тулгар төр Хүннү гүрний соёл иргэншлийн өвөрмөц онцлог, хамрах хүрээг нээх, дэлхий дахины түүхэнд гүйцэтгэсэн үүргийг шинээр авч үзэх, хот суурин, үйлдвэрлэлийн судалгааг өргөжүүлж, Монголчуудын өвөг дээдэс мөн болохыг тогтоох, олон улсын эрдэмтдээр хүлээн зөвшөөрөгдсөн бүтээл туурвих, “Өвөг Монголчуудын түүх-соёл” олон улсын тогтмол хурал зохион байгуулах, Сяньби, Жужан, Түрэг, Уйгур, Киданы үеийн түүх, археологийн дурсгалыг Монгол улсын нутгаас шинээр нээж олох, түүх, угсаа-соёлын тулгамдсан асуудлыг эх сурвалжаар судлаж Монголын эртний түүхийн цогц бүтээлүүд туурвина. Мөн эртний улсуудаар мэргэшсэн мэргэжилтнүүдийг бэлтгэж сургана.

б) Монголын эзэнт гүрэн ба дундад зууны үеийн түүхийн салбарын зорилт: Монголын дундад зууны үеийн түүхийн зангилаа асуудлыг шийдвэрлэх, VI-XVII зуун хүртэлх Монгол болон харь угсааны улсуудын улс төр, эдийн засаг, хууль цааз, шашин суртахуун, ёс заншил, соёл, гадаад харилцаа зэрэг үндсэн асуудлыг судлах, Монголын түүхчдийн “Рах Mongolica” буюу “Монголын ертөнц”-ийн талаарх байр суурийг бататган бэхжүүлэх, дундад зууны түүхийн судалгаанд перс, араб, латин, хятад, түрэг, манж, түвэд хэлний эх сурвалжуудыг ашиглан тулгуур бүтээлүүдийг туурвих, Хархорум, Аурагийн орд, Хар балгас зэрэг археологийн томоохон дурсгалуудад суурин судалгаа явуулах, Монголын эзэнт гүрний түүхэнд холбогдох гадаад улсад буй дурсгалуудыг хамтран судлах, ном, бүтээл, үзэсгэлэн гаргах, харилцааны шинэ нөхцөл бий болгоно. Монголын эзэнт гүрний дараахь үеийн Монголчуудын бүтээсэн өв соёл, түүхэнд гүйцэтгэсэн байр суурь зэргийг тодорхойлох бүтээлүүдийг туурвина.

в) Орчин үе, бүс нутгийн түүхийн салбарын зорилт: XVII-XXI зууны Монголын түүхийг бүс нутгийн түүхэн үйл явдлуудтай холбон судалж Ази, Дорно дахин, дэлхийн шинэ үеийн түүхэн үйл явцад монголчуудын гүйцэтгэсэн үүрэг, оролцоог тодруулах, хамрах

хүрээг өргөтгөсөн судалгааг хийж, XVII-XX зууны эхэн үеийн Монгол-Манж-Оросын харилцаа, XX зууны монгол туургатны улс төр, аж ахуй-эдийн засаг, угсаа-соёл, хил хязгаар, шашин шүтлэг, пост коммунист үеийн Монгол улс ба бүс нутгийн харилцааг судлах, дотоод, гадаадын архив, номын сан, музейн сан хөмрөгт хадгалагдаж буй түүхийн баримт, эд өлгийн болон аман түүхийн судалгааг эрчимжүүлэх, сан бүрдүүлэлт хийж, судалгааны эргэлтэд оруулах ажлыг гүйцэтгэнэ. Орчин үежилтийн үеийн Монголын гадаад ертөнцийг нээж харах, холбогдох түүхэн сурвалж бичгүүдийг судалгааны эргэлтэд оруулах, XX зууны Монголын тусгаар тогтнолын гадаад ертөнц, дотоод зүй тогтолыг судлан шинжилсэн бүтээлүүд гаргана.

г) Угсаатан ба нийгмийн хүн судлалын судалгааны салбарын зорилт: Монгол угсаатны угсаа-гарвал, угсаатны бүрэлдэхүүний түүх, уламжлалт аж ахуй, зан заншил, эдийн болон оюуны соёлын өвийг гүнзгийрүүлэн судлаж, өвлүүлэн уламжлуулах хөтөлбөр боловсруулах, монголын нүүдэлчдийн биет бус өвийн судалгааг технологи, инновацийн талаас нь нягтлан судалж, судалгааны өөрийн гэсэн дэг сургууль буй болгож, Монголын нийгмийн бүхий л салбарын судалгааг цогцоор нь судлах ажлыг гүйцэтгэнэ. Нийгэм соёлын хүн судлалын онолын үүднээс нийгмийн хөгжлийн асуудлуудыг судлах, биет бус өвийн судалгааг өргөжүүлэх, төрөл зүйл бүрээр нь нягтлан онолын үндэслэлтэй судлах зорилт тавина.

д) Хэрэглээний угсаатан судлал, биет бус соёлын өвийн судалгааны төв: “Монгол угсаатны өв” нэгдсэн мэдээллийн сан (database) бүрдүүлэх, орчин үеийн угсаатны нийгэм-соёлын үйл явц (өөрчлөлт, ижилсэл), соёлын биет бус өв, технологийн нөлөөллийг тогтоох, “Монголын Үндэсний угсааты музей - лаборатори” үндэслэл боловсруулж танилцуулах, Монгол угсаатны бүлгүүдийг бүрдүүлж буй бүлгүүдээр тус бүр нэг ном гаргах ажлыг гүйцэтгэнэ. Монгол угсаатны биет бус өвийн судалгааг цогцоор нь судлах хамгийн томоохон судалгааны төв болно.

е) Сурвалж судлал, баримт, мэдээллийн төвийн зорилт: Монголын түүх-соёлын судалгааны баримт хэрэглэгдэхүүний үндэсний хэмжээний тулгуур төвийг буй болгож, түүхэн сурвалж, баримт бичиг, хээрийн шинжилгээний эх хэрэглэгдэхүүн, гэрэл зураг, дуу, дүрс бичлэг, эд өлгийн зүйлс, дуртгал, дурсамжийн нэгдсэн сан бүрдүүлэх, “Дэлхийд тархсан Монголын түүхийн өв сан”, “Дурсгалт бичгийн чуулган” зэрэг цувралуудыг нийтлүүлэх, Монголын түүхийн цахим номын сан, мэдээллийн бүртгэлжүүлэлт хийх, тус төвд хадгалагдаж байгаа баримтуудыг бүрэн онлайн болгох ажлыг хийж гүйцэтгэнэ. Тус төвөөс Монголын түүхийн сурвалж бичгийн бүхий л үеийн дурсгалуудын сан хөмрөг буй болгох, сурвалж бичгийн мэргэжлийн судлаачдын баг бүрдүүлэх болно. Монгол улсын нийт нутаг дэвсгэрийг хамарсан угсаатны зүйн буюу биет бус өвийг авран хамгаалах хээрийн шинжилгээний ажлыг гүйцэтгэх, энэ чиглэлийн хайгуул, судалгааг өргөтгөх, үндэсний хэмжээний мэдээллийн сан үүсгэх, “Монгол улсын нутаг дэвсгэр дэх биет бус өвийн судалгаа” газар зүйн мэдээллийн 1:1.000.000 масштабтай зураг үйлдэх, соёлын биет бус өвд нөлөөлөх эрсдлийн үнэлгээг тодорхойлж, арга зүйг боловсруулах, удирдлагаар хангах, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, түүх, соёлын өвийн судалгааг олон нийтэд түгээн таниулах, сурталчлах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

ё) Академич Б.Ширэндэвийн дурсгалын танхим: Монголын нэрт түүхч, шинжлэх ухааны зүтгэлтэн, академич Б.Ширэндэвийн нэрэмжит танхим нь тус хүрээлэнгийн уламжлал, сан хөмрөгийн нэг хэсэг бөгөөд цаашид тус танхимыг зөвхөн нэг хүний төдий бус нэр алдартай эрдэмтэн судлаачдын дурсгал хүндэтгэлийн танхим болгож өргөтгөнө.

Л.Дэндэв, Ц.Пунцагноров, Д.Цэдэв, Ш.Нацагдорж нарын эрдэмтэн судлаачдын алдар гавъяаг харуулсан хүндэтгэлийн танхим болгоно.

3.2. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны зорилтууд

1. Хүрээлэнгийн бүтэц, зохион байгуулалтыг өөрийн байгууллагын хөгжлийн онцлог, түүхэн уламжлал, эрдэм шинжилгээний ажлын туршлагатай уялдуулан олон улсын жишиг, чиг хандлагад нийцүүлэн боловсруулж шинэчилж байх, Хүрээлэнгийн 4 жилийн хөгжлийн төлөвлөгөө, суурь болон судалгааны бусад төсөл хөтөлбөр, үр дүнгийн гэрээнүүдийг боловсруулан хэрэгжүүлнэ.

2. Хүрээлэн дээр соёлын бүтээлч үйлдвэрлэлийг буй болгох гарааны компани байгуулах, инновацийн үйл ажиллагаанд дотоодын болон гадаадын байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран оролцох, соёлын өвийг тулгуурлан соёлын аялал жуулчлалыг буй болгоно. Монголын Үндэсний Угсаатны музей байгуулах үндэслэл, уг суурийг тавих болно.

3. Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажлын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, олон улсын, гадаадын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих, захиалгат болон хамтарсан судалгааны ажил гүйцэтгэх менежмент хийнэ.

4. Нийгэмд шинжлэх ухааныг таниулан сурталчилах. Олон улсын болон үндэсний хэмжээний мэргэжлийн нийгэмлэг, холбоодыг дэмжиж хамтран ажиллана.

Хүрээлэнгийн боловсон хүчний нөөц бололцоо чадавхийг дээшлүүлэх

1. Дэлхийн монгол судлал, дорно дахин судлал, түүх, угсаатны судлал, археологийн чиглэлээр өндөр хөгжилтэй орнууд болон эх орны их дээд сургуулиудад нарийн мэргэжлийн чиглэлээр магистрантур болон докторантурт залуу ажилтнуудыг суралцуулах, мэргэжил дээшлүүлэх богино урт хугацааны сургалтанд хамруулах, судалгааны лабораториудад ажиллуулах, зочин судлаач болон профессороор урин ажиллуулах, их, дээд сургуулиудтай хамтран угсаатны судлалын тэнхимийг байгуулан ажиллуулах, нарийн мэргэжлийн хичээл заана.

2. Хүрээлэнгийн номын санг тусгай бие даасан хэмжээнд хүртэл өргөтгөх, ахмад болон гадаадын нэртэй монгол судлаач, археологич эрдэмтдийн номын сангаар баяжуулах, электрон ном сантай болох, интернетээр нэн чухал зарим электрон номын санг ашиглах эрх нээх, архивын баримт, судалгааны тайланг онлайнаар бүгдийг оруулж дуусгана.

3. Гадаадад суралцаад төгсгөсөн чадварлаг эрдэмтэн судлаачдыг хүрээлэндээ эргэн ирж ажиллах нөхцөл боломжоор хангах, дотоодын судалгааны ажилд оролцоход нь дэмжлэг үзүүлж, тодорхой хэмжээний төсөл хөтөлбөр бие даан удирдуулах, тухайн суралцсан улсынх нь их дээд сургууль, судалгааны газруудтай хамтран ажиллуулах боломжоор хангана.

Хүрээлэнгийн техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх

1. Дотоод, гадаад нөөц бололцоог ашиглан судалгааны суурин болон нүүдлийн шинэ багаж төхөөрөмж авах, судалгааны хамтарсан лаборатори, танхим, төв, оффис байгуулах техникийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэх, судалгааны шинэ техник, технологийг түүх, угсаатан судлал, археологи, сурвалж судлалын судалгаанд ашиглах ажлыг хэвшүүлэн нутагшуулна.

2. Хүрээлэнгийн дотоод нөөц бололцоог ашиглан угсаатны сан хөмрөг, лаборатори байгуулах, түүхийн эх сурвалж судлалын судалгааны төв нээх баг ажиллуулна.

3. Археологи, угсаатны судлалын чиглэлийн гол багаж хэрэгслийг худалдан авч судалгаанд хэрэглэх, угсаатны мэдээллийн нэгдсэн сан байгуулах программыг худалдан авах, олон улсын хэмжээний түүхийн баримт, гэрэл зургийн мэдээлэлийн сан байгуулах. Мэдээлэлийн санг Англи, Унгар зэрэг орны эрдэмтдийн дэмжлэгээр байгуулж, бусад тоног хэрэгслийг өндөр хөгжилтэй хамтран ажиллаж буй улс орнуудаар хангуулах боломжийг судлана.

4. Орон нутаг дахь бүс нутгийн судалгааны төвүүдийг хадгалах, хамгаалах нөхцлийг буй болгож, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, үзүүлэгийг сайжруулах, шаардлагатай барилга, мэдээллээр хангаж хөгжүүлнэ.

5. Хүрээлэнд Монголын түүх, угсаатан судлал, археологийн баримтат кино үзэх, сургалтын зориулттай жижиг студи байгуулан 3D кино үзвэрийн танхим нээж, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг мэдээллээр хангах танхимтай болгоно.

Хүрээлэнгийн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх

1. Дэлхийн монгол судлал, дорно дахин судлал, түүх, угсаатны судлал, археологийн чиглэлээр их дээд сургууль, олон улсын судалгааны төвүүдтэй идэвхтэй хамтрах, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ хэлэлцээр шинээр байгуулж, гадаадын судалгааны төвүүдэд өөрийн хүрээлэнгийн салбар, төвүүдийг байгуулна.

2. Хамтарсан судалгааны төв, хээрийн судалгааны газар, бүс нутгийн төвүүдийг байгуулах, гадаадын монгол судлаачдыг урих хөтөлбөрөө улам өргөжүүлж, шинээр хүрээлэнгийн дэргэд **“MONHIS FOUNDATION”** байгуулан түүнээс гадаадын монгол судлаачдыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3. Хүрээлэнгийн Дэлхийн түүхчдийн холбооны гишүүнчлэлийг улам өргөжүүлж, дэлхийн түүхийн холбооны ээлжит хурлыг зохион байгуулах ажлыг Монгол улсад явуулах, дэлхийн Монгол судлалын Их хурлын гол зохион байгуулагч байгууллага болох, Дэлхийн Дорно дахины судлалын Их хурлыг Монгол улсад анх удаагаа зохион байгуулах боломжийг судлах, Бүх Оросын угсаатны судлал, Хүн судлалын нийгэмлэгийн албан ёсны гишүүн байгууллага болох зэрэг идэвхтэй хамтын ажиллагааг өрнүүлнэ.

Хүрээлэнгийн дэд бүтэц, тулгуур цэгүүдийг байгуулах

1. Хүрээлэнгийн дэргэд Монголын Үндэсний Угсаатны музейг байгуулах ажлын бэлтгэл хангах, үзэл баримтлалыг боловсруулах ажлыг эрчимжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах ажлыг 2025 он гэхэд бүрэн төлөвлөж музей байгуулах ажлыг хөөцөлдөнө.

2. Хүрээлэнгийн байрыг засварлах, өрөө тасалгааг судалгааны орчинд тохируулан бага зэрэг өөрчлөх, нэгдсэн байрны дээврийг өргөн мансарт хийж судалгааны лабортори болон бусад археологийн дурсгалуудыг хадгалах зориулалтын байр барих боломжийг судлах ажлыг гүйцэтгэнэ.

3. Хөвсгөл нуур, Өмнөговь аймагт Умард бүсийн болон Өмнөд бүсийн хээрийн судалгааны төвийг байгуулах ажлыг эхлүүлэх болно. Өмнөд бүсийн судалгааны төвийг цайны замын чиглэл дагуу Дундговь аймгийн нутагт тус тус биет бус соёлын өвийн төвүүд байгуулагдах бэлтгэл ажлыг эхлүүлнэ. Мөн аялал жуулчлалын сүлжээнд нэгтгэн аялал жуулчлалын гол төв байгуулах ажлыг эхлүүлэх болно.

ДӨРӨВ. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТУУД

Хүрээлэнгийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь 2 үе шаттайгаар хэрэгжинэ. Дунд хугацааны хүрээлэнгийн хөгжлийн төлөвлөгөө нь 4 жилийн хугацаатай

ШУА-ийн Ерөнхийлөгч болон Хүрээлэнгийн захирлын дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр дээр суурилсан байна. Богино хугацааны үе шат нь Хүрээлэнгийн 1 жилийн үр дүнгийн гэрээ, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө болно.

4.1.Хүрээлэнгийн 4 жилийн хөгжлийн төлөвлөгөө

Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн 4 жилийн хөгжлийн төлөвлөгөөг хүрээлэнгийн захирлын дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийг үндэслэн боловсруулж, Хүрээлэнгийн Эрдмийн Зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталж ажиллана. Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажлын ирэх 4 жилд хөгжүүлэн өргөжүүлэх төлөвлөгөөг ШУА-ийн Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөр, Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн салбарын хууль, тогтоомж, бусад эрх зүйн баримт бичгүүд, улс орны нийгэм, эдийн засгийн болон Шинжлэх Ухаан Технологийн хөгжлийн түвшин, олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн боловсруулна. Хөгжлийн төлөвлөгөөнд дараах зүйлүүдийг тусгана. Үүнд:

- Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажлын үндсэн чиглэл, тэргүүлэх чиглэлийг Стратеги төлөвлөгөөний хүрээнд тодотгож олон улсын шинжлэх ухааны тухайн салбарын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн, улс орны хөгжлийн бодлоготой уялдуулна.

- Хүрээлэнгийн бүтэц, удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгож, цахим удирдлагын систем бий болгон, мэдээлэлийн нэгдсэн сүлжээг ашиглан судлаачдад бэрхшээлгүй асуудлыг шийдэх боломжоор хангана.

- Хүрээлэнд хэрэгжүүлсэн суурь судалгааны болон захиалгат төслүүд, хамтарсан төслийн үр дүнг нийгмийг соён гэгээрүүлэх, төрийн бодлого үйл ажиллагааг явуулахад, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, инновацийн үйл ажиллагааны талаар гарсан санаачилгыг дэмжиж ажил хэрэг болгоно.

- Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажлын санхүүжилтийг тогтвортой байлгах, боломжоороо нэмэгдүүлэх, бусад эх сурвалжуудад тулгуурлан асуудлыг шийдвэрлэнэ.

- Хүрээлэнгийн хүний нөөцийн одоог хүртэл барьж ирсэн бодлогыг цаашид тогтвортой байлгах, залуу эрдэмтдийг сонгон ажиллуулах, судлаачдын түвшинг дээшлүүлэх, дүгнэх, бүтээлч үр дүнг шаардана.

- Барилга, байгууламж, лабораторийн нөхцлийг сайжруулж, боломжийн хүрээнд нэмэлт санхүүжилт босгож, зарим бүтээн босгох ажлыг эхлүүлнэ.

- Бусад мэргэжлийн ижил төстэй байгууллага, их дээд сургууль, музей, номын сан, архивтай судалгаа, сурталчилгааны чиглэлээр хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалт, семинар зохион байгуулах, шинжлэх ухааныг нийгэмд танин мэдүүлэх, сурталчлах бүхий л үйл ажиллагаанд идэвхтэй оролцож тэргүүлэн удирдана.

- Хүрээлэнгийн гадаад хамтын ажиллагааг Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд тогтвортой явуулж, цаашид хүрээг тэлж, монголын түүх, соёл уламжлалын судалгаа явуулдаг байгууллага, хувь хүмүүстэй хамтран ажиллана.

- Эрдэм шинжилгээний болон нийгмийн бусад байгууллагууд, эрдэм түгээх, соён гэгээрүүлэх, танин мэдүүлэх ажлыг зохион байгуулахаас гадна төрийн бодлого үйл ажиллагаанд үндэсний дархлааг хэрхэн хадгалах, цаашид түүний талаар явуулах бодлогод нөлөөлөлийг үзүүлж, аюулгүй байдлыг хангахад зөвлөмж өгөх зэргээр ажиллана.

4.2.Хүрээлэнгийн нэг жилийн үр дүнгийн гэрээний төлөвлөгөө

Хүрээлэнгийн нэг жилийн үр дүнгийн гэрээ болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Шинжлэх Ухааны Академийн тэргүүлэгчдийн газраас баталсан удирдамж чиглэлийн дагуу хүрээлэнгийн 4 жилийн хөгжлийн төлөвлөгөө, хүрээлэнгийн стратеги төлөвлөгөөний хүрээнд боловсруулж, биелэгдэх боломжтой ажлуудыг эхний жилүүдэд түлхүү хэрэгжүүлнэ.

ТАВ. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНХҮҮГИЙН ХҮРЭЭ, БОЛОМЖ

Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн хүрээг гадаад болон дотоод, оюуны болон биет хөрөнгө оруулалт гэсэн хэсгүүдээр тодорхойлж байна.

5.1. Дотоод хүрээ, боломж

- Стратеги төлөвлөгөөний хүрээнд хэрэгжих шинэ сэдэв, төслүүдийг нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглүүлэх, үр дүн нь бүс нутгийн болон дэлхийн шинжлэх ухаанд дорвитой хувь нэмэр оруулсан байх, үр дүн нь шууд болон шууд бус хэлбэрээр бүтээгдэхүүн болж үр ашгаа өгдөг байхаар боловсруулан улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

- Тус хүрээлэнгийн онолын суурь судалгааны хүрээнд хуримтлагдсан хээрийн судалгааны материал, суурин судалгааны эх хэрэглэгдэхүүн, тэдгээрийг боловсруулж гаргасан үр дүнгүүд нь Монголын болон бүс нутгийн болон дэлхийн судалгааны сан хөмрөгт Монголын эрдэмтдийн оруулж буй хувь нэмэр болно. Ялангуяа Монгол улсын нутаг дэвсгэрт хийгдэж буй угсаатан судлал, археологийн чиглэлийн хээрийн судалгааны үр дүн, малтлага, хайгуул судалгааны мэдээллүүд нь дэлхийн өөр бусад улсын соёлтой харьцуулах, тодруулах, судалгааны цоо шинэ хэрэглэгдэхүүн болдог юм.

- Онолын суурь судалгаа, шинжлэх ухаан технологийн төслийн судалгааны материалуудын бодит өртгийг нарийвчлан тодорхойлох, түүнийг хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн болгон зах зээл дээр борлуулах замаар жилдээ 100- 200 сая хүртэлх төгрөгийн орлого олж, Хүрээлэнгийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн үндсэн эх үүсвэрийг бий болгоно. Хүрээлэнд биет бус соёлын өвийн инновацид түшиглэсэн компани байгуулагдах болно.

- Төрийн болон болон хувийн хэвшлийн бизнесийн байгууллагуудтай хамтран шинжлэх ухаан, технологийн бүхий л хэлбэрийн төслүүдийг хэрэгжүүлж хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг татна.

- Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрүүдэд судалгаа шинжилгээний ажлын чиглэлийн дагуу хамрагдан оролцож явуулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудтай хамтран ажиллах замаар санхүүжилтийн бас нэгэн эх үүсвэрийг бий болгоно.

5.2. Гадаад хүрээ, боломж

- Монгол орон нь түүх, угсаа соёлын аж ахуй, археологийн дурсгалын хувьд эрдэм шинжилгээний үйл ажил ажиллагаа явуулахад нэн тохиромжтой, гадаадын эрдэмтэн судлаачдын сонирхлыг байнга татаж байдаг онцлогт тулгуурлан гадаад хамтын ажиллагааг хайгуулын болон малтлагын төслүүд хэлбэрээр хэрэгжүүлж, гадаад санхүүжилтийн үндсэн эх үүсвэрийг бүрдүүлнэ.

- Олон улсын түвшинд болон гадаад түншүүдтэй хамтран ажиллаж хэрэгжүүлэх техникийн үйл ажиллагааны хүрээнд судалгааны багаж тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах, үйл ажиллагааны зардал болох 40-50 мянган ам. долларыг (1 жилд дунджаар) олох нөхцөлийг бүрдүүлнэ.

- Түүх, угсаатан судлал, археологийн чиглэлээр хамтран ажилладаг улс орнуудын зүгээс дэмжлэг авахаас гадна АНУ, Англи, Франц, Герман, Япон, Солонгос, БНХАУ, Унгар, Казахстан болон бусад орны эрдэмтэдтэй хамтран боловсруулж жилд дунджаар 10-20 мянган ам.долларын санхүүжилтийг олон улсын, тухайн орны шинжлэх ухаан, технологийн төслийг хэрэгжүүлэх сангаас олох боломжтой гэж үзэж байна.

Хүрээлэнгийн үүсэл хөгжлийн түүхэн тойм

XX зууны Монголын түүхэнд хийгдсэн хамгийн чухал бүтээн байгуулалтын нэг бол шинжлэх ухааны өвийг Монголчууд буй болгож чадсан явдал юм. Шинжлэх ухааны байгууллагыг анх 1921 оны 11 сард хуучин бичгийн хүмүүс, түшмэл Жамсраны Цэвээн зэрэг хүмүүс Богд Жибзундамбад “Бичиг судрын хүрээлэн” байгуулахыг мэдүүлсний хариуд “мэдэв” хэмээн зөвшөөрүүлснээр эрдэм судлалын анхны байгууллагын шанг татаж, бүтээн босгох их үйлс эхэлсэн.

Тус хүрээлэнгийн анхны зорилгын нэг нь Түүхийн судалгааг явуулах, түүхийн ном судрыг судлах, түүхийн зохиол бүтээл туурвих үндсэн зорилгыг хангах зорилтын хүрээнд анхны суурь нь буй болсон. Тэр цаг үеэс судар бичгийн хүрээлэнгийн үндсэн гол судалгаа нь хэл бичиг, түүх, хүн ардын аж байдал (*ethnograph*)-ийн судалгаа байсан бөгөөд 1933 онд Судар бичгийн хүрээлэн Шинжлэх Ухааны хүрээлэн болгон өргөтгөж бүтцийн өөрчлөлт хийхэд Түүхийн кабинетийг албан ёсоор байгуулан их зохиолч Д.Нацагдоржийг анхны даргаар нь тохоон томилсон байдаг.

Улмаар 1941 оны 8 сарын 28-наас Шинжлэх ухааны хүрээлэн хуралдаж гаргасан 106 тоот тушаалаар Түүхийн кабинетийг өргөтгөн Түүхийн тасаг болгож жижиг Нацаг буюу хожмын ШУА-ийн дэд Ерөнхийлөгч Академич Ш.Нацагдоржийг томилжээ.

1940-өөд оноос түүхийн судалгааны марксист онол арга зүйгээр судлах ажлыг БНМАУ-ын төрөөс даалгасан ч мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэн анхны түүхч, археологичид төрөн гарсан. 1961 онд Монгол улсад ШУА албан ёсоор байгуулагдахад анхны хүрээлэнгүүдийн нэг- Түүхийн хүрээлэн байгуулагдаж улмаар археологи-этнограф, орчин үеийн түүх гэсэн хэдэн салбартайгаар үйл ажиллагаагаа эхэлсэн түүхтэй.

Тэр цагаас хойш Монгол улсын бүрэн түүхийг бичих, археологи-угсаатны судалгаа хийх ажлыг эрчимтэй өрнүүлж 1954 онд “БНМАУ-ын түүх” нэгэн боть, 1966-1968 онд “БНМАУ-ын түүх” гурван боть, 1984 онд “БНМАУ-ын түүх”-ийн нэгэн ботийн нэмэн засварласан хэвлэл, 1999-2002 онд “Монгол Улсын түүх” таван боть бүтээлүүдийг туурвиж, “Монгол улсын угсаатны зүй” 3 ботийг 1987-1995 оны хооронд бүтээж, 2016 онд “Монголын археологийн өв” 7 боть бүтээл, Монгол улсын угсаатны судалгааны тайлан 11 боть, Монголын археологийн шинэ судалгаа, шинэ хандлага 3 боть бүтээлүүдийг хийж гүйцэтгээд байна.

Эдүгээ 4 салбар, 2 төв, 1 танхимтай үйл ажиллагаагаа явуулж, Монгол улсын түүхийн 25 боть бүтээлийг туурвих ажил хийгдэж эхлээд байна. Ийнхүү Монгол улсад тогтвортой суурь судалгаа явуулах бүрэн түүх уламжлалтай, цаашид зөв бодлого, зөв стратеги боловсруулан ажиллах бололцоотой төдийгүй бүс нутаг, дэлхийн хэмжээнд судалгааны бүтээл хийж чадах боломжтой хүрээлэн болж чадсан байна.

1. Евразийн нүүдэлчид, эртний төрт улсын түүх, археологийн судалгааны салбарын товч танилцуулга

Монголын шинжлэх ухааны ууган байгууллага Судар бичгийн хүрээлэн байгуулагдахад “... хөшөө, булш, хуучин хот, хэрмийг шинээр нээн олж, хөндөн малтах” ажил түүний үндсэн зорилгын нэг болж байв. 1924 онд Судар бичгийн хүрээлэнгийн бүрэлдэхүүнд тус тусдаа үйл ажиллагаа явуулж асан хуучны судлалын кабинет, түүхийн кабинет хоёрыг нэгэн доор хамт байхаар төлөвлөн, эртний судлалын ажлыг хариуцуулжээ. Энэ үед О.Жамьян, Ж.Цэвээн, Н.Дэндэв, Д.Нацагдорж нар Зөвлөлтийн мэргэжилтнүүдийн

хамт болон дангаараа түүх соёлын дурсгалыг илрүүлэн судлах, Монголын нууц товчооны зарим газар орныг сурвалжлан тогтоох ажлуудыг хийж гүйцэтгэж эхэлсэн бөгөөд, 1920-1930 оны хооронд хийгдсэн хайгуул, шинжилгээний ажлаар Монголын археологи, угсаатан судлалын үндэс тавигдсан нь тухайн үеийн түүх судлалын нэг чухал ололт байв.

1930 онд Судар бичгийн хүрээлэнг Шинжлэх ухааны хүрээлэн болгон өргөтгөж, 1935 оноос Түүхийн тасаг бий болсон нь эртний судлалыг илүү өргөн хүрээнд өрнүүлэх боломж нөхцлийг буй болгожээ. “БНМАУ-ын түүх” анхдугаар нэгэн боть туурвих бэлтгэл ажлын хүрээнд 1948-1949 онд зохион байгуулагдсан Монгол-Зөвлөлтийн түүх-этнографийн хамтарсан экспедицийн бүрэлдэхүүнд Түүхийн кабинетын ажилтан Х.Пэрлээ, Ц.Доржсүрэн, мөн тухайн үед Москвагийн их сургуульд суралцаж байсан оюутан Н.Сэр-Оджав, Д.Наваан нарын үндэсний мэргэжилтнүүд судлаачаар оролцсон нь шинэ цагийн Монголын археологийн хөгжлийн үндсийг тавьжээ.

1961 онд Шинжлэх ухааны хүрээлэнг ШУА болгон өргөжүүлэн шинээр зохион байгуулахад, түүний харьяа анхны таван хүрээлэнгийн нэг - Түүхийн хүрээлэнд археологи-этнографийн секторыг байгуулсан нь Монголын эртний түүх, соёлын судалгааг дагнан эрхлэх мэргэжлийн анхны бүтэц болсон юм. Энэ үеэс Монгол-Зөвлөлтийн түүх, соёлын хамтарсан экспедиц жил дараалан ажиллах болсны зэрэгцээ БНАГУ, Унгар зэрэг орны археологич эрдэмтэдтэй өргөн хүрээнд судалгаа хийх болсон нь салбарын бэхжилтэнд чухал нөлөө үзүүлжээ. 1985 онд Угсаатан судлалын салбар байгуулагдахад Монголын эртний түүх, археологийн судалгаа нь Археологи болон Дундад зууны секторт төвлөрөн хийгдэх болжээ.

1998 оноос тус хүрээлэнд Археологийн судалгааны төв байгуулагдаж, улмаар 2002 оны 8 сарын 9-ний өдрийн Монгол улсын Засгийн газрын тогтоолоор Археологийн судалгааны төвийг бие даалган Археологийн хүрээлэнг байгуулсан тул Түүхийн хүрээлэнд Монголын эртний түүх, археологийн судалгааг Дундад зууны салбарын чиг үүргийн хүрээнд түр хавсаргаж байгаад 2003 онд Эртний түүхийн сектор (эрхлэгч Д.Эрдэнэбаатар)-ыг байгуулж, тухайн чиглэлийн судалгааг дагнан эрхлүүлэх болгожээ.

2006 онд Түүхийн хүрээлэнд хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөр Түүх бичлэг, сурвалж судлалын секторыг татан буулгаж, Эртний түүхийн салбар (эрхлэгч С.Өлзийбаяр) болгон өргөжүүлсэн байна. Тус салбарын эрдэмтэн судлаачид 2001-2007, 2008, 2010 онд Улаанбаатарын их сургууль, ОХУ-ын Санкт-Петербургийн их сургуультай хамтарсан “Төв Азийн археологийн шинжилгээ” хээрийн судалгаа, 2008-2009 онд ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, төвд, буддын судлалын хүрээлэнтэй хамтарсан “Хил хязгааргүй Сэлэнгэ” хээрийн судалгаа, 2011-2012 онд “Хүннүгийн түүх, соёлын мөрөөр”, 2013-2015 онд “Онон”, 2014-2015 онд “Эгийн голын УЦС-ын авран хамгаалах экспедици” болон авран хамгаалах хайгуул зэрэг гадаадтай хамтарсан болон үндэсний хээрийн судалгааг хийж иржээ.

Мөн хугацаанд “Монголын эртний түүх” (Монгол улсын шинжлэх ухаан 108 боть цувралын 27-р боть) /УБ., 2009/, “Монголын эртний түүх бичлэг: МЭӨ III зуунаас өмнө (Монгол улсын судлаачдын бүтээлээр) /УБ., 2011/ нэгэн сэдэвт зохиолууд, “Эрт, дундад үеийн монголчуудын аж ахуй, соёл” /УБ., 2006/, “Монголын түүхийн шинжлэх ухаан” (Монгол улсын шинжлэх ухаан 108 боть цувралын 26-р боть) /УБ., 2007/, “Монголын эртний нүүдэлчид (МЭӨ II мянганы дундаас МЭӨ III зуун)” /УБ., 2014/ хамтын бүтээлүүдийг туурвижээ. Тэдгээрийн дотроос доктор Б.Батсүрэнгийн “Өндөр тэрэгтнүүд ба эртний түрэгүүд (VI-IX зуун)” нэгэн сэдэвт зохиол 2009 оны Шинжлэх ухааны шилдэг бүтээлийн дэд байрын шагнал хүртсэн байна.

Монгол улсын Монгол улсын Засгийн газрын 2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 27-р тогтоолоор Түүх, археологийн хүрээлэн байгуулагдахад тус салбарыг Хүннү ба эртний түүхийн судалгааны салбар (эрхлэгч Ч.Ерөөл-Эрдэнэ) болгон өргөжүүлсэн юм. Тус салбарын бүрэлдэхүүнд 2015-2017 онд “Эртний Дотоод Азийн түүхэн орон зай дахь монгол хэлт аймгууд”, 2018-2020 онд “Хүннүгийн дараах нүүдэлчид-II” хэмээх суурь судалгааны төсөлт ажлыг хэрэгжүүлж, сэдэвт ажлын хүрээнд судалгааны анги, багийн түвшинд хээрийн судалгааг жил дараалан хийж, мөн “Монголчуудын гарал үүсэл, угсаа соёлын цогц судалгаа” шинжлэх ухаан технологийн төслийн хээрийн судалгааг 2015-2016 онд, СУИС-тай хамтарсан “Хатны булгийн нууц” шинжилгээний ангийг 2016-2018 онд тус тус ажиллуулсан болно. Мөн авран хамгаалах чиглэлийн археологийн судалгааг хийсээр ирсэн юм.

Тус салбарын эрдэм шинжилгээний ажилтан Б.Батсүрэнгийн “Ухуань (авар) ба Сяньби (сэрби)” /УБ., 2016/, С.Өлзийбаяр, Б.Очир, Э.Уртнасан нарын “Хүннүгийн түүх, соёлын судалгаа (Салхитын амны дурсгалт газар)” //Монголын археологийн шинэ судалгаа. Цуврал–VI. /УБ.,2019/ зэрэг нэгэн сэдэвт зохиолууд хэвлэгдсэний дотор Б.Батсүрэн, С.Өлзийбаяр нарын гол зохиогчоор оролцсон “Монголын эртний түүх” таван боть зохиол 2017 оны Монголын шинжлэх ухааны шилдэг бүтээлээр шалгарсан юм.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн “Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 328 тоот тогтоолын дагуу ШУА-ийн Тэргүүлэгчдийн 2019 оны 10 сарын 03-ны өдрийн хурлын 07 тоот тогтоолын 7-р хавсралтаар баталсан шинэ бүтцээр *Евразийн нүүдэлчид, эртний төрт улсын түүх, археологийн судалгааны салбар* (эрхлэгч С.Өлзийбаяр) байгуулагдан Монголын эртний түүх, археологийн судалгааг эрхлэн гүйцэтгэж байна.

2.Монголын эзэнт гүрэн ба дундад зууны үеийн судалгааны салбарын товч түүх

Дундад зууны судалгааны салбар нь тус хүрээлэнгийн ууган салбарын нэг. Анх секторын эрхлэгчээр доктор Г.Сүхбаатар, доктор М.Санждорж, доктор А.Очир нарын зэрэг манай нэртэй түүхчид ажиллаж байсны дээр ШУА-ийн сурвалжлагч гишүүн, доктор Х.Пэрлээ, академич Ш.Нацагдорж, академич Ч.Далай, академич Н.Ишжамц, доктор Д.Гонгор, Ц.Насанбалжир нарын зэрэг алдартай эрдэмтэн мэргэд тус салбараас төрөн гарсан билээ.

2015 онд Түүх, археологийн хүрээлэн байгуулагдахад тус салбар нь шинэчлэгдсэн бөгөөд өнөөдрийн байдлаар эрдэм шинжилгээний 13 ажилтантай, салбарын эрхлэгчээр доктор, дэд профессор Ц.Цэрэндорж, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтнаар доктор, профессор С.Цолмон, доктор, дэд профессор А.Пунсаг, доктор, дэд профессор Ц.Энхчимэг, эрдэм шинжилгээний ахлах ажилтан доктор А.Энхтөр, эрдэм шинжилгээний дэд ажилтнаар доктор Л.Ганбат, магистр Р.Мөнхтулга, Л.Мөнхбаяр, Т.Батбаяр, Г.Батболд, Ч.Энхтуул, Д.Ананд, Б.Мөнхбилгүүн нар ажиллаж байна.

Тус салбарын ажилтнууд нь монгол, тод, дөрвөлжин бичиг, орос, англи, герман, хятад, япон, солонгос, турк, араб зэрэг сурвалжийн болон судалгааны хэлийг эзэмшсэн, судалгааны арга туршлагатай, мэргэжлийн өндөр чадвартай судлаачдаас бүрдэж байна.

Тус салбарын судалгааны гол чиглэл нь X-XVII зуун хүртэлх Монголын түүхийн суурь судалгаа болох улс төр, эдийн засаг, хууль цааз, шашин суртахуун, ёс заншил зэрэг хийгээд мөн үед холбогдох хот суурин, сүм хийдийн тур, булш оршуулга, тахилга тайлгын онгон, хадны зураг, бичээс зэрэгт холбогдох археологийн баримт, хэрэглэгдэхүүнүүдийг боловсруулж нарийвчлан судлахад оршино. Өмнөх судалгааны үр дүнг түшиглэж монгол,

хятад, орос болон бусад хэл дээрх сурвалж, судалгааны материалыг өргөнөөр ашиглаж, тодорхой цаг үе, газар нутаг, тодорхой үйл явдлыг судалгааны объект болгож, гүнзгийрүүлэн судалгаа хийснээр Монголын түүхчдийн байр суурийг дэлхийн эрдэмтэн судлаачдын дунд бэхжүүлэх, монгол эрдэмтний үзэл бодол, дуу хоолойг хүргэхэд оршино.

Тус салбар нийт 7 зохиол бүтээл болон нэгэн сэдэвт хамтын бүтээлүүд бичиж олон нийтийн хүртээл болгожээ. Тухайлбал, Чингис хааны өв /УБ., 2012/ каталоги хэвлүүлснээс гадна “Чингис хаан Дэлхийн түүхнээ” /УБ., 2012/, “Чингис хааны эзэнт гүрэн” /УБ., 2012/ хэвлүүлэв. Мөн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан доктор, дэд профессор А.Пунсаг “Монголын Нууц Товчоон дахь ёс заншил, зан үйлийн тайлбар толь” /УБ., 2012/, эрдэм шинжилгээний ажилтан Ц.Минжин “Их Монгол улсын заргач Шихихутаг” /УБ., 2011/, “Түүхийн жимээр дорноос өрнө лүү” /УБ., 2011/ зохиолуудыг тус тус бичиж олны хүртээл болгожээ. Эдгээрээс 2011-2012 онд Дундад зууны Монголын түүхийн судалгааны салбар шагнал бүтээлээрээ 2 шагнал авч байв. Үүнд: “Чингис хааны өв” /УБ., 2012/ каталоги нь Жак Уэтерфорд болон Жак Уэтерфорд сангийн нэрэмжит 2012 оны шилдэг бүтээлийн өргөмжлөл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит 2012 оны шилдэг залуу судлаачаар Ц.Минжин /2012 он/ хүртэж байв. Хубилай сэцэн хаан мэндэлсний 800 жилийн ойг тохиолдуулан ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс эрхлэн 9 боть зохиолыг туурвисан.

Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр Их Монгол улсын тав дахь их хаан Хубилай Сэцэн хааны мэндэлсний 800 жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд БСШУЯ, Шинжлэх ухааны академи, Олон улсын Монгол судлалын холбоотой хамтран 2015 оны 9 дүгээр сарын 21, 22-нд зохион байгуулав. 2015 онд Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр Их Монгол улсын тав дахь их хаан Хубилай сэцэн хааны мэндэлсний 800 жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд БСШУЯ, Шинжлэх ухааны академи, Олон улсын Монгол судлалын холбоотой хамтран 2015 оны 9 дүгээр сарын 21, 22-нд зохион байгуулсан “Хубилай Сэцэн хаан ба Монголын Юань улс” олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцэгдсэн илтгэлүүдийн эмхтгэлийг хэвлүүлэв. Мөн доктор Ц.Цэрэндорж “Монголын эзэнт гүрэн хийгээд Корйө: Хубилай засаглалын үүсэл ба Корйөгийн улс төрийн статус” /УБ., 2016/ бүтээлийг орчуулан хэвлэв. Тус бүтээлд 1260 онд Хубилай засгийн эрхэнд гарсан үйл явдал, Монголын эзэнт гүрний хувь заяа, Монгол – Солонгосын харилцаанд ямар нөлөө үзүүлснийг өрнө дорнын олон хэлээр буй сурвалж бичигт тулгуурлан нягтлан судалж, сонирхолтой, шинэ саналыг дэвшүүлсэн байдаг.

2. Орчин үе, бүс нутгийн түүхийн судалгааны салбарын товч танилцуулга

Хүрээлэнгийн ууган салбаруудын нэг болох Шинэ түүхийн тасгийн эх суурь тэртээх 1960 оны эхээр тавигджээ. Шинжлэх ухаан, дээд боловсролын хүрээлэнгийн даргын 1960 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн тушаалаар Түүх, эдийн засгийг судлах газрыг Хэл зохиол судлах газартай нэгтгэж, Хэл зохиол, түүх судлах газрыг 6 тасагтай байгуулсны нэг нь Шинэ, нэн шинэ түүхийн тасаг байв. Тасгийн анхны эрхлэгчээр Д.Цэдэв, эрдэм шинжилгээний ажилтнаар Ц.Насанбалжир нар томилогдон ажиллажээ.

1961 онд БНМАУ-ын Шинжлэх ухааны Академи байгуулагдахад анхны таван хүрээлэн нэг болсон Түүхийн хүрээлэнгийн Шинэ, нэн шинэ түүхийн тасгийг өргөтгөн орон тоог нэмэгдүүлжээ. Энэ үед тус тасгийн эрхлэгчээр Б.Түдэв, эрдэм шинжилгээний ажилтнаар Д.Цэдэв, Г.Цэрэндорж, Гончиг, Н.Дангаасүрэн, М.Санждорж зэрэг судлаачид ажиллаж, ШУА-ийн ерөнхийлөгч Б.Ширэндэв судалгааны ажлаа тус тасагт гүйцэтгэж байжээ. 1960-аад оны сүүл үеэс Л.Дүгэрсүрэн, Д.Дашжамц, Ш.Сандаг нарын түүхчид нэмэгдэн ирж, ХХ

зууны Монголын түүхийн чиглэлээр томоохон судалгаа явуулж, “БНМАУ-ын түүх” гурван боть бүтээлийн III ботийг туурьвих ажлыг тус тасаг гүйцэтгэжээ.

1970-1990 онд тасгийн эрхлэгчээр доктор Б.Түдэв, М.Санждорж, доктор Ж.Болд нар, эрдэм шинжилгээний ажилтнаар доктор Л.Бат-Очир, доктор А.Минис, дэд эрдэмтэн Г.Цэрэндорж, М.Ринчин, Б.Чинчулуун, эдийн засгийн ухааны доктор Сэнгэд, эрдэм шинжилгээний ажилтан Б.Роломжав, С.Туяа, Б.Энхбаяр, М.Цэцэглэн, Н.Хишигт, И.Саруул, Д.Бумаа, М.Ариунсайхан нар ажиллаж байв.

1990-2010 онд Шинэ түүхийн тасгийг доктор М.Санждорж, дэд доктор М.Ринчин, З.Лонжид, Н.Хишигт, доктор Ч.Дашдаваа нар удирдаж, академич Б.Лхамсүрэн, академич Ж.Болдбаатар, түүхийн шинжлэх ухааны доктор Л.Жамсран, О.Батсайхан, түүхийн ухааны доктор Ж.Болд, Г.Дашням, И.Саруул, Б.Пунсалдулам, Д.Өлзийбаатар, эдийн засгийн ухааны доктор Г.Баянжаргал нарын тэргүүлэх эрдэмтэд ажиллаж, Б.Батгөмөр, Б.Энхчимэг, Д.Эрдэнэбат, О.Дариймаа, Ч.Батдорж нарын залуу судлаачдаар бэхэжсэн байв.

Судалгааны ажлын хамрах хүрээ өргөжсөнтэй уялдуулан 2010 онд Шинэ түүхийн тасаг нь Орчин үеийн Монголын түүхийн салбар, 2015 оноос Түүх, археологийн хүрээлэнгийн Бүс нутаг, орчин үеийн түүхийн салбар, 2019 оноос Орчин үе бүс нутгийн салбар болон өөрчлөгджээ.

1990-ээд онд салбарын эрхлэгч, доктор М.Санждоржийн удирдлагаар “XX зууны Монгол” судалгааны төслийг эхлүүлж, түүхийг үзэх шинэ хандлага, арга зүйг төлөвшүүлэх эхлэлийг тавьсан “Хорьдугаар зууны Монгол. Түүхэн тойм” анхны бүтээл 1995 онд хэвлэгдсэнээс хойшхи хугацаанд XX зууны Монголын улс төр, нийгэм-эдийн засаг, боловсрол, шинжлэх ухаан, соёлын түүхийн зангилаа асуудлуудыг судлан шинжилсэн суурь судалгааны 6 сэдэвт ажил, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, төвд, буддын судлалын хүрээлэнтэй хамтарсан эрдэм шинжилгээний 2 төслийг тус тус хэрэгжүүлж, нэгэн сэдэвт зохиол, хамтын бүтээл, баримт бичгийн эмхтгэл, намтар судлалын бүтээл, түүх-гэрэл зургийн цомог зэрэг 40 шахам бүтээлүүдийг хэвлүүлжээ.

Эдүгээ доктор, профессор Г.Мягмарсамбуугийн удирдсан тус салбарын эрдэмтэн судлаачид “БНМАУ-ын нийгэм, эдийн засгийн ололт: туршлага, сургамж /1954-1980-аад оны сүүлч/”, “БНМАУ: социализм ба бурхны шашин (1944-1990)” суурь судалгааны 2 төсөл, хамтарсан 1 төслийг хэрэгжүүлж, гадаад, дотоод хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.

5. С.Бадамхатаны нэрэмжит Угсаатан ба нийгмийн хүн судлалын салбарын товч танилцуулга

Тус салбар нь анх 1950-иад оны сүүл үед БНМАУ-ын Шинжлэх ухааны хүрээлэнгийн Түүх судлах газрын дэргэд “Археологи-Этнографийн тасаг” нэртэй анх байгуулагджээ. Тухайн үед “Археологи-Этнографийн тасаг”-ийн эрхлэгчээр нэрт эрдэмтэн археологич Н.Сэр-Оджав ажиллаж байв.

1959-1962 оны хооронд С.Бадамхатан тэргүүтэй угсаатны зүйчид Хөвсгөлийн Дархад, Цаатан ардын дунд угсаатны зүйн хээрийн судалгаа хийж С.Бадамхатан “Хөвсгөлийн цаатан ардын аж байдлын тойм” /1962/, “Хөвсгөлийн дархад ястан” /1965/ хэмээх алдарт бүтээлүүдээ туурвисан байна.Түүнчлэн Халхын угсаатны зүйн судалгаанд С.Бадамхатангийн 1968-1970 онд Боржгин халхчуудын дунд явуулсан угсаатны зүйн судалгааны үр дүнд нийтэлсэн “Боржгин халх” хэмээх бүтээл тэдгээр бүтээлүүдийн үргэлжлэл болон хэвлэгджээ. Энэ бүтээлд халхын нэгэн хэсэг “Боржгин халх” гэж өөрсдийгөө нэрлэдэг Төв аймгийн Баянжаргалан, Дорноговь аймгийн Сүмбэр (хуучнаар), Даланжаргалан, Айраг, Иххэт,

Дундговь аймгийн Цагаандэлгэр, Говь-Угтаал, Баянжаргалан сумдын хүн ардын түүх, аж ахуй, эдийн болон оюуны соёлыг угсаатны зүйн цогцолбор аргачлалаар судалж Боржгин халхчуудын ахуй, соёлын өвөрмөц онцлогийг харуулсан байна.

1960-аад оны үеийн угсаатны судалгаа манай орны зарим ястан, угсаатны бүлгүүдийн гарал угсаа, тэдгээрийн эд, оюуны соёлын онцлогийг тодруулах зорилгоор судалж байсан бол 1970-аад оноос манай ард түмний угсаатны хөгжлийн явц, социалист нэгдмэл монгол үндэстэн бүрэлдэн тогтсон асуудлыг нэгтгэн дүгнэхийг оролдож эхэлсэн байна. 1970-аад оны сүүл үеэс Түүхийн хүрээлэнд ажиллаж байсан угсаатны зүйчид биеэ даасан тасаг байгуулах санал удаа дараа тавьж байсны үр дүнд 1985 онд “Археологи-Этнографи”-ийн тасгаас салбарлан биеэ дааж “Угсаатны зүйн сектор” байгуулагдсан байна. Монголын угсаатны зүйн судалгааны нэгэн чухал ололт нь ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс “Монгол улсын угсаатны зүй” I, II, III боть зохиолыг туурвисан явдал юм. Уг гурван боть зохиолыг 1980-1985 онд I боть буюу Халхын угсаатны зүй, 1986-1990 онд II боть буюу Ойрадын угсаатны зүй, 1991-1995 онд III боть буюу Монгол, Түрэг, Хамниган зэрэг монголын нийт угсаатны бүлгүүдийг бичиж, хэвлүүлжээ.

Угсаатны зүйн гурван боть зохиолд монголын олон ястнуудын (*угсаатны бүлгүүдийн*) угсаа түүх, аж ахуй, амьдралын орчин дахь уламжлалт дэг ёс, уламжлалт соёлын элементүүдийн талаарх эх материал, мэдээллийн санг (database) бүрдүүлж байсан нь өнөөгийн гадаад, дотоодын угсаатан судлаачдын гол эх сурвалж нь болжээ.

Тус салбар нь жил бүр Монголын олон ястан, угсаатны бүлгүүдийн дунд угсаатны зүйн хээрийн судалгаа явуулж ирсэн бөгөөд 1958 оноос эхлэн эдүгээх хүртэлх хугацаанд тус орны 21 аймаг, 200 гаруй суманд нийт 50-иад удаагийн хээрийн шинжилгээний ажлыг зохион байгуулсан ба хээрийн шинжилгээний эх хэрэглэгдэхүүн, тайлангууд эдүгээ Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн сан хөмрөгт хадгалагдаж байна. Эдгээр хээрийн шинжилгээний тайлангуудыг 2011 онд Англи улсын Кембрижийн их сургуулийн “Монгол ба Дотоод ази судлалын төв”-тэй хамтарсан төсөл хэрэгжүүлсэний үр дүнд 10 боть болгон хэвлүүлж, олны хүртээл болгоод байна. Мөн түүнчлэн 1959 оноос монголын түүх, угсаатны зүйн асуудлуудыг хөндсөн “Этнографийн судлал” хэмээх эрдэм шинжилгээний цуврал бичгийг эрхлэн гаргаж эхэлсэн ба сүүлийн жилүүдэд дээрх цувралын нэрийг “Угсаатан судлал” болгон өөрчилж эдүгээ нийт 20 гаруй боть цуврал хэвлэгдэн олны хүртээл болоод байна.

Тус салбар нь 2008 оноос Угсаатан судлал, антропологийн салбар болон өргөжиж, дэлхийн жишигт нийцүүлэн, судалгааны арга зүй, чиг хандлагаа өөрчлөн ажиллах болов. 2015 онд тус салбарын 30 жилийн ой тохиосон бөгөөд тус ойн хүрээнд салбарыг Нэрт угсаатны зүйч С.Бадамхатаны нэрэмжит болгосон бөгөөд “Угсаатан судалгааны салбар” болгон хуучин нэрэнд өөрчлөлт оруулсан байна. Өнөөдрийн байдлаар тус салбарын эрхлэгчээр Доктор (Т.Билэгсайхан) ажиллаж, докторант Г.Бямбарагчаа, магистр Э.Дагвадорж, гэрээт ажилтнаар доктор Г.Цэрэнханд нар ажиллаж байна.

Тус салбарын судлаачид өнгөрсөн хугацаанд ОХУ, Япон, Англи зэрэг улсуудын их сургууль, судалгааны хүрээлэнгүүдтэй хамтарсан судалгааны төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлсээр ирсэн бөгөөд дотоодын их дээд сургууль, судалгааны хүрээлэнгүүд болон төрийн болон төрийн бус хэвшлийн олон арван байгууллагуудтай хамтарсан үндэсний хэмжээний судалгааны төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсээр иржээ.

Тус салбар нь гадаад, дотоодын судалгааны олон байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлсээр ирсэн бөгөөд тэдний заримаас дурдвал, Их Британи улсын Кембридгийн их сургуулийн Монгол ба Дотоод ази судлалын төв, Япон улсын Шига мужын Их сургууль, ОХУ-ын Тува улсын Хүмүүнлэгийн судалгааны хүрээлэнгийн Монгол

судлалын салбар, ОХУ-ын Буриад улсын их сургуулийн Социологийн салбар зэрэг их сургууль, хүрээлэнгүүдийг нэрлэж болно.

5.Хэрэглээний угсаатан судлал,бие бус соёлын өвийн төв

“Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 328 дугаар тогтоолын дагуу ШУА-д хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөр тус хүрээлэн нь Түүх, угсаатны зүйн хүрээлэн болж, шинэ бүтцэд Угсаатны зүйн салбар нь судалгааны чиглэл зорилгын дагуу хоёр хуваагдахад Хэрэглээний угсаатан судлал, биет бус соёлын өвийн судалгааны төв байгуулагдсан болно.

Тус төвд эрхлэгч, доктор Н.Маралмаа, эрдэм шинжилгээний ажилтан докторант М.Энхбаатар, Б.Батцоож, магистр У.Пүрэвжав, Н.Гонгоржав нарын залуу судлаачдаас бүрдсэн баг ажиллаж, 1950-иад оны сүүл үеэс БНМАУ-ын Шинжлэх ухааны хүрээлэнгийн Түүх судлах газрын дэргэд анх байгуулагдсан Археологи-Этнографийн тасгаас явуулсан угсаатны зүйн судалгааны арвин баялаг өвд тулгуурлан, салбарын суурь судалгааны цар хүрээг орчин үеийн нийгмийн хэрэгцээ шаардлагатай уялдуулан өргөжүүлэхийг зорьж байна. Эл зорилгоор Биет ба биет бус соёлын өв, хэрэглээний угсаатан судлалаар дагнан ажиллаж, эн тэргүүнд Монголын угсаатны зүйн судалгааны нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг хийх эхлүүлэн ажиллаж байна.

Мөн Монголын соёлын өвийн үндэсний төв, Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн Түүх, ёс заншлын албатай гадаад, дотоодын цөөнгүй судалгааны байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Үүнд: Унгар улсын "Элтэ" их сургуулийн Төв Ази ба Монгол судлалын тэнхим, Өвөр Монголын Их Сургуулийн Нийгмийн ухааны дээд сургууль, Монгол судлалын дээд сургууль, хамтран ажиллаж буй зэргээс дурдаж болох билээ.

6. Сурвалж судлал, баримт мэдээллийн төвийн тухай танилцуулга

Түүх, угсаатны зүйн хүрээлэн (ТУХ)-гийн Түүхийн баримт мэдээллийн төв (ТБМТ) нь 2006 оны 12 дугаар сард ШУА-ийн Тэргүүлэгчдийн шийдвэрээр Монголын түүхийн судалгааны баазыг өргөжүүлэх зорилгоор байгуулагдсан. Манай төв нь эрдэм шинжилгээний дэд ажилтан 1, дадлагажигч ажилтан 1, эрдэм шинжилгээний туслах ажилтан 3, гэрээт ажилтан 2 бүгд 7, /Доктор (Ph.D) 1. Магистр 3/ ажилтантайгаар ажиллаж байна.

Эдүгээ ТБМТ-ийн сан хөмрөгт тус хүрээлэн анхлан үүсэн байгуулагдсан 1921 оноос хойш өнөөдрийг хүртэл 96 жилийн хугацаанд Монгол улсын түүхийг судлан боловсруулах эрдэм шинжилгээ судалгааны ажлын явцад түүх, археологи, угсаатны судлалын холбогдолтой эх болон хуулбар, нэн ховор баримтаар бүрдүүлсэн 4967 хадгаламжийн нэгжийн 231207 хуудас баримтыг 11 сан хөмрөгт ангилан хадгалж судалгаанд ашиглуулж байна. XVII-XX зууны Монголын түүхэнд холбогдох эх сурвалжууд буюу Манж Чингийн үе дэх Монгол орон, 1911, 1921 оны хувьсгал, феодализмын хоцрогдлоос үсрэнгүй дэвшилд хүрсэн түүхэн замналыг харуулсан баримт бичгүүд. Орчин цагийн түүхийн шинжлэх ухаан үүсч хөгжин Монгол орны түүхийг эртний үеэс эдүгээг хүртэл улируулан судалж бүтээсэн БНМАУ-ын түүхийн нэгэн боть, гурван боть, Монгол улсын түүхийн таван боть, “БНМАУ-ын соёлын түүх” хоёр боть, “Монголын иргэншлийн түүхийн асуудал”, “Орчин цагийн угсаатны явц ба социалист хэрэглэгдэхүүн” арван боть зэрэг хамтын томоохон бүтээлүүдийн гар бичмэл, эх ноорог хадгалагдаж байна.

1920-1950 оны түүхийг хамарсан баримт бичгүүдэд Монгол оронд Монгол Ардын Нам (МАН) байгуулагдаж Зөвлөлт Орос Улс Коминтерний дэмжлэг тусламжтайгаар гадаадын түргэмгийлэгчдээс эх орноо чөлөөлж тусгаар тогтнолоо байлдан олж хөгжил

дэвшилд хүрсэн, хөгжлийн замд гарсан алдаа гажуудал, хэлмэгдүүлэлтийн тухай өгүүлдэг. Үүнд монголын хувьсгалчид ЗОУ-ын Засгийн газар, Коминтернтэй холбоо тогтоож хамтран ажилласан, Хоёр улсын хооронд байгуулсан 1921, 1931, 1936 оны найрамдал, хамтын ажиллагаа, худалдааны гэрээ хэлэлцээрүүд, улаан армийн цэрэг монголд орж ирсэн, цагаантныг даран сөнөөсөн, монголын нам төрийн удирдагчид, ЗОУ-ын удирдагчид Ленин, Сталин, Коминтерний төлөөлөгчидтэй харилцсан, уулзсан, илгээсэн захидал, илгээлт тэмдэглэл зэрэг 44 баримт бичиг, нийтдээ орос хэл дээр 171 хн-ийн 18160 хуудас баримт хадгалагдаж байна.

Суурь судалгааны олон бүтээлүүдийг туурвих явцад цуглуулсан үндсэн баримт хэрэглэгдэхүүнүүд болох нэрт эрдэмтэн Ж.Цэвээн, Л.Дэндэв, Ш.Нацагдорж, Ц.Насанбалжир, Г.Навааннамжил, Х.Пэрлээ, Ц.Пунцагноров, С.Бадамхатан, Д.Гонгор, Л.Бат-Очир нарын бүтээлүүдийн эх бичвэрүүд, Хүрээлэнгийн төлөвлөгөө тайлан, хээрийн судалгаа, түүх, археологи, угсаатны зүйн үндэсний болон хамтарсан экспедицүүдийн тайлан, эрдмийн зэрэг хамгаалсан диссертацууд байна.

XX зуунд Монгол оронд болж өнгөрсөн түүхэн үйл явдлуудад оролцсон 888 хүний дуртгал, намтар. XIX-XX зууны үеийн монголчуудын аж амьдрал түүхэн үйл явдлыг харуулсан 4500 гаруй гэрэл зураг, баримтат кино, хуурцаг, кассет, сд-нүүд хадгалагдаж байна. Судлаач эрдэм шинжилгээний ажилтнууд, түүх сонирхогчдод зориулан сан хөмрөгт хадгалагдаж буй 1921 оноос хойш цуглуулсан 3263 хадгаламжийн нэгжийн 99182 хуудас баримт бичгийг нээлттэй болгож “ШУА-ийн түүхийн хүрээлэнгийн баримтын бүртгэл”-ийн 1 дүгээр дэвтрийг 2010 онд хэвлүүлсэн нь олон нийтийн талархлыг хүлээсэн ажил болсон.

ТБМТ-ийн үйл ажиллагааны нэг үндсэн чиглэл нь эрдэм шинжилгээний ажилтнуудад номын сангаар үйлчилж хэрэгцээт ном, мэдээллээр хангах явдал юм. Өнөөдрийн байдлаар номын санд 23564 ш ном байгаа бөгөөд эдгээр номуудыг эрэлт хайлтын “Коха” системд оруулан шаардлагатай ном мэдээллээр эрдэм шинжилгээний ажилтнуудыг шуурхай ханган ажиллаж байна. Тус хүрээлэнгээс 1921 оноос хойш эрхлэн хэвлүүлсэн 923 ном, бүтээл болон түүхийн судлал, угсаатны судлал, археологийн судлал зэрэг эрдэм шинжилгээний сэтгүүлийн 133 дугаар хадгалагдаж байна. Эдгээр сэтгүүлүүдийг бүрэн эхээр нь хүрээлэнгээс эрхлэн гаргадаг www.mongoltoli.mn вэб сайтад байршуулж олон нийтийн хүртээл болгосон. Сүүлийн жилүүдэд хүрээлэнгийн гадаад харилцаа өргөжиж эдүгээ 16 орны 56 судалгааны байгууллага, Их дээд сургууль, судалгааны төв, музейтэй хамтран ажиллаж байгаагаас зөвхөн 2016 онд ОХУ, Их Британи, Польш, Иран улсын архив, судалгааны байгууллагуудаас 8500 баримт бичиг хуулбарлан авчирч сан хөмрөгөө баяжуулсан.

Сүүлийн жилүүдэд судалгаа шинжилгээний ажлын олон жилийн үр дүнд хуримтлагдсан баримт материалыг дижитал хэлбэрт оруулан онлайнд байршуулж монголын түүх сонирхон судалдаг хэн боловч дэлхийн аль ч өнцөг булангаас тус хүрээлэнд хадгалагдаж буй баримт эх хэрэглэгдэхүүнийг судлах боломжийг нээх зорилгоор “Монголын түүхийн холбогдолтой баримтын нэгдсэн сан” (XIII-XX зуун) суурь судалгааны төслийг санаачлан ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд сан хөмрөгт хадгалагдаж буй баримт эх сурвалжаас 1813 хадгаламжийн нэгжийн 1666 баримтын 28412 хуудас материалыг стандартын дагуу цэгцлэх, баримт бичгийг онлайн хэлбэрт оруулахад бэлтгэх ажлыг хийж гүйцэтгээд байна.

ХҮРЭЭЛЭНГИЙН ЧИГ ҮҮРЭГ

Евразийн нүүдэлчид, эртний төрт улсын түүх, археологийн судалгааны салбарын үйл ажиллагааны үндсэн чиглэл

Монголын анхны тулгар төр Хүннү гүрний соёл иргэншлийн өвөрмөц онцлог, хамрах хүрээг нээх, дэлхий дахины түүхэнд гүйцэтгэсэн үүргийг шинээр авч үзэх, хот суурин, үйлдвэрлэлийн судалгааг өргөжүүлж, Монголчуудын өвөг дээдэс мөн болохыг тогтоох, олон улсын эрдэмтдээр хүлээн зөвшөөрөгдсөн бүтээл туурвих, “Өвөг Монголчуудын түүх-соёл” олон улсын тогтмол хурал зохион байгуулах, Сяньби, Жужаны үеийн археологийн дурсгалыг Монгол улсын нутгаас шинээр нээж олох, түүх, угсаа-соёлын тулгамдсан асуудлыг эх сурвалжаар судлах,

- Монгол болон бус нутагт тархсан Хүннүгийн эзэнт гүрний түүхэнд хамаарах археологийн дурсгалын нэгдсэн сан хөмрөг буй болгох,

- Судалгааны ажлыг эрчимжүүлэх, ном бүтээлүүдийг хэвлэн нийтлүүлэх,

- Холбогдох газруудад хайгуул судалгааг явуулах, шинээр нээж илрүүлэх, тусгайлсан лабораторийн шинжилгээ хийх, нүүдлийн болон суурин амьдралын хоорондын харилцаа, аж ахуйн онцлог, хот байгуулалтын онцлог зэргийг судлах,

- Археологийн дурсгалын он цагийг тодруулах, эрт үеийн түүхэнд хамаарах дурсгалуудыг тусгайлан судлах, хүрэл болон төмөр зэвсгээс Хүннүгийн үед шилжих ишлжилтийн үеийн түүхийг тодруулах,

- Хүннүгийн дараа үед Монгол нутагт оршин тогтнож байсан Сяньби, Жужан зэрэг улсуудын түүх соёлын харилцаа, уламжлалын асуудлыг тодруулах судалгааг явуулах,

- Илэрч олдсон дурсгалуудад нарийвчилсан судалгааны ажлыг явуулах бөгөөд нас тогтоох шинжилгээг хийлгэх, харьцуулсан судалгаа явуулах зэрэг болно.

Хамрах хүрээ. Монгол улсын нутаг дэвсгэрийг бүрэн хамран бөгөөд хөрш зэргэлдээ улс орнуудын тухайн он цагт хамаарагдах дурсгалын талаарх судалгааг хамруулан авч үзэж болно. Судалгааны эх хэрэглэгдэхүүн боловсруулахад мэргэжлийн ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллана.

Өвөрмөц нөхцөл байдал. Хүннү, Жужаны археологийн дурсгалын гол цөм нутаг дэвсгэр болно. Хүннүгийн дурсгалын хамгийн томоохон цогцолбор дурсгал нь монгол нутагт байна. Харьцангуй Хүннүгийн судалгааны ажил монгол нутагт их хэмжээгээр хийгдсэн. Туршлага, хариуцлага судлах дурсгал, судалгааны арга зүй төлөвшсөн байдалтай.

Хөрөнгө оруулалт. Монгол улсын ШУТС-ын дэмжлэгээр суурь судалгааны ажлын хүрээнд санхүүжигдэж байна.

Судалгааны багийн чадавхи. Хүний нөөцийн хувьд одоогоор докторын зэрэгтэй 2 судлаач, эрдэм шинжилгээний 4 ажилтан байна. Хүний нөөц хангалттай бус, 3-5 ажилтан нэмж авах шаардлагатай. Лабораторийн ажилтан шаардлагатай, мөн түүний нөхцөл байдлыг сайжруулах. Урт хугацааны томилолтыг нэмж авч үзэх, түүх бичлэг, сурвалж судлал, түүх бичлэгийг анхаарах хэрэгтэй байна.

Монголын эзэнт гүрэн ба дундад зууны үеийн түүхийн салбарын үйл ажиллагааны үндсэн чиглэл

Монголын дундад зууны үеийн түүхийн зангилаа асуудлыг шийдвэрлэх, XIII-XVII зуун хүртэлх Монгол болон харь угсааны улсуудын улс төр, эдийн засаг, хууль цааз, шашин

суртахуун, ёс заншил, соёл, гадаад харилцаа зэрэг үндсэн асуудлыг судлах, Монголын түүхчдийн “*Rex Mongolica*” буюу “*Монголын ертөнц*”-ийн талаарх байр суурийг бататган бэхжүүлэх, дундад зууны түүхийн судалгаанд перс, араб, латин, хятад, түрэг, манж, түвэд хэлний эх сурвалжуудыг ашиглан тулгуур бүтээлүүдийг туурвих, Монголын эзэнт гүрний түүхэнд холбогдох гадаад улсад буй дурсгалуудыг хамтран судлах, ном, бүтээл, үзэсгэлэн гаргах, харилцааны шинэ нөхцөл бий болгох;

- *Монголын эзэнт гүрний түүхэнд холбогдох шинэ сурвалж эх хэрэглэгдэхүүнийг судалгааны эргэлтэд оруулах, Жишээлбэл, Солонгос, Перс, Араб зэрэг урьд өмнө судалгааны эргэлтэд монголын хувьд бага орж байсан хэлний эх сурвалжуудыг судалгааны эргэлтэд оруулах, орчуулах, хэвлэн нийтлэх;*

- *Түүхийн судалгааг археологийн судалгаатай уялдуулан хөгжүүлэх, түүхийн онол арга зүйн зарчмыг удирдлага болгох, археологийн судалгааны шинэ ололт амжилтыг харьцуулан судлаж тухайн үеийн түүхэн үнэн бодитой судалгааг явуулах;*

- *Монголын эзэнт гүрний түүх, археологийн судалгааны хүрээг тэлж (гадаадын зарим улс орнуудад зохион байгуулах, (Алтан ордон улс, Ил хаант улс, Цагаадайн улс) жишээлбэл, ОХУ, Казахстан, Иран, Киргиз зэрэг улс орнуудыг дурдаж болно.*

- *Монгол төрийн залгамж, уламжлалыг XII-XVII зууны хооронд түүхэн уялдаа холбоонд нь авч үзэж судлах, энэ чиглэлээр тусгай төслүүдийг хэрэгжүүлж, судалгааны ажлыг өргөтгөх;*

- *Монголын эзэнт гүрэн болон монголчуудын дэлхийн болон бүс нутагт гүйцэтгэсэн нөлөөлөл, өвийг судлах;*

- *Өгүүлэн буй үеийн Монголын гадаад харилцааны түүхийг судлах, ялангуяа Монгол-Орос, Монгол-Манж, Монгол-Солонгос, Монгол-Дундад Ази гэсэн чиглэлээр судалгаа явуулах, ном бүтээл туурвих;*

Хөрөнгө оруулалт. Шинжлэх Ухаан Технологийн сан, улс хоорондын гэрээ хэлэлцээр, дотоодын компанийн талаас хөрөнгө оруулалт авах. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд хээрийн судалгааны хөрөнгийг татах.

Үйл ажиллагааны хамрах хүрээ. Гадаад, дотоодын их дээд сургуулийн эрдэм шинжилгээний байгууллагуудтай холбогдох, он цагийн хувьд XIII зуунаас XVII зууны үеийг хамрана.

Өвөрмөц байдал. Монголын түүхийн чухал үе болох Монголын эзэнт гүрний үеийн түүхийн судалгааны хамрах хүрээ, бүс нутгийн болон дэлхий нийтийн эрдэмтдийн сонирхолыг татах боломж, судалгааны явагдсан түвшингийн хувьд бусад салбараас илүү өргөн хүрээтэй хийгдсэн. Монголын эрдэмтдийн эзэнт гүрний үеийн өмнөх болон дараах үеийн түүхийн үзэл баримтлалыг тодорхойлох боломжтой.

Судалгааны багийн чадавхи. Мэргэжлийн хувьд XII-XVII зууны бүх цаг үеийг хамарч судалгаа хийдэг мэргэжилтнээс бүрдсэн. Их Монгол улс, Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүн улсууд, эзэнт гүрний дараах үеэр мэргэшсэн түүхч боловсон хүчинтэй, эртний хятад, араб, турк, солонгос, япон, манж, орос, англи, герман зэрэг сурвалжийн болон судалгааны гадаад хэлтэй судлаачдаас бүрдэж байна. Хоёр докторантыг гадаадад сургах, 3-5 эрдэм шинжилгээний ажилтан нэмж авах шаардлагатай байна.

Орчин үе, бүс нутгийн түүхийн судалгааны салбарын үйл ажиллагааны үндсэн чиглэл

XVII-XXI зууны Монголын түүхийг бүс нутгийн түүхэн үйл явдлуудтай холбон судалж Ази, Дорно дахин, дэлхийн шинэ үеийн түүхэн үйл явцад монголчуудын гүйцэтгэсэн

үүрэг, оролцоог тодруулах замаар өргөн цар хүрээтэй судалгааг хийж, XVII-XX зууны эхэн үеийн Монгол-Манж-Оросын харилцаа, XX зууны монгол туургатны улс төр, аж ахуй-эдийн засаг, угсаа-соёл, хил хязгаар, шашин шүтлэг, пост коммунист үеийн Монгол улсын бүс нутагт эзлэх байр суурь, улс орны хөгжлийн түүхийн зангилаа асуудлуудыг дотоод, гадаадын архив, номын сан, музейн сан хөмрөгт хадгалагдаж буй түүхийн баримт, эд өлгийн болон аман түүхийн судалгааг эрчимжүүлэх, сан бүрдүүлэлт хийж, судалгааны эргэлтэд оруулах,

- Бүс нутгийн түүхэнд монголчуудын гүйцэтгэсэн үүрэг, улс төрийн байр суурийг судлан тодорхойлох,

- Барга, Өвөр Монгол, Шинжиан, Тува урианхай, Буриад зэрэг Монголын бүс нутгийн гадна буй монгол туургатан ард түмний монгол үндэсний түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, эзлэх байр суурь, соёл, аж ахуйн онцлог, уялдаа холбооны тухай асуудлыг тусгайлан судлах,

- Тусгаар тогтнолын төлөөх монголчуудын тэмцэл, түүний үр дүн, учирсан саад бэрхшээл, түүхэн сургамжийг нэгтгэн судлах замаар тусгаар тогтнолын үнэ цэнийг тодорхойлох,

- Монгол улсын социалист бүтээн байгуулалтын түүхийг аж үйлдвэр, хөдөө аж ахуй, газар тариалан, шинжлэх ухаан, соёл, боловсрол, хүн ам зүй, эрүүл мэнд, биеийн тамир спорт зэрэг салбаруудаар цогцоор судлах,

- XX зууны Монголын гадаад орчин, гадаад бодлого, гадаад харилцаа, хамтын ажиллагааны түүхийн судалгааг өргөжүүлэх,

- XX зууны Монголын нийгмийн амьдралд шашны гүйцэтгэсэн үүрэг, эзлэх байр суурь, төр-шашны харилцааны түүх, шашны зүтгэлтнүүдийн намтрыг судлах,

- Монголын түүхэн зүтгэлтэн, түүхэн үйл явдлыг тэгш ойг тэмдэглэн өнгөрүүлэх үндэслэлийг боловсруулж, ойн хүрээнд түүхэн зүтгэлтнүүдийн намтар, үйл ажиллагааг судлан, тодруулах, холбогдох архивын баримтуудыг хэвлэн нийтлэх, (Партизануудын болон ахмад зүтгэлтнүүдийн дурсамж, аман түүх г.м)

- Өгүүлэн буй үеийн түүхтэй холбоотой гадаад, дотоодын архив, номын сан, музейд хадгалагдаж байгаа Монголын түүхийн өв соёлыг судлах, бүртгэл хийх, хэвлэн нийтлүүлэх

Хамрах хүрээ. Ижил төстэй судалгаа явуулдаг гадаад, дотоодын судалгааны хүрээлэн, их сургууль, архив, номын сан, музей болон хувь хүмүүс

Өвөрмөц нөхцөл байдал. Монгол улсын хэмжээнд энэ чиглэлийн судалгааг дагнан гүйцэтгэдэг нэгж бөгөөд, сурвалж, баримт материал, судалгааны ном бүтээлийн баялаг өвтэй.

Хөрөнгө оруулалт. Суурь судалгааны төсөлт ажил болон захиалгат төсөл, грант, хандив, тусламж,

Судалгааны багийн чадавхи. Одоо нийт 9 судлаач байна. Үүнд: академич 1, шинжлэх ухаан (Sc.D) доктор 1, доктор (Ph.D) 5, магистр 2. Судлаачид нь Монголын орчин үеийн түүхийн суурь судалгааг он удаан жил гүйцэтгэж ирсэн туршлагатай, мэргэжлийн ур чадвар өндөр ахмад, дунд, залуу үеийнхний төлөөлөл болно. Цаашид англи, япон, солонгос зэрэг гадаад хэлний мэдлэг боловсролтой, судалгааны арга зүй эзэмшсэн 2-3 залуу судлаач нэмж авч ажиллуулах шаардлагатай байна.

Угсаатан ба нийгмийн хүн судлалын салбарын үйл ажиллагааны үндсэн чиглэл

Угсаатны зүй, соёлын биет бус өвийн судалгааны хээрийн шинжилгээний эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан, Гадаад, дотоодын мэргэжлийн судалгааны байгууллагуудтай

хамтарсан судалгааг хөгжүүлж, Монгол улс дахь Нийгэм-соёлын хүн судлалын ухааны хөгжлийг олон улсын хөгжлийн түвшинд хүргэж Төв болон Умард Азийн бүс нутаг судлалын судалгааны тэргүүлэх төв болно. Тэргүүн зорилгыг биелүүлэх үүднээс ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн С.Бадамхатаны нэрэмжит Угсаатан судлал, нийгмийн хүн судлалын салбарын үе үеийн судлаачдын хийж ирсэн судалгаа, эрдэм шинжилгээний түүхэн туршлага, нөөц болон орчин үеийн хүн судлалын ололтод тулгуурлан Монгол улс дахь Угсаатан судлалын шинжлэх ухааны хөгжлийн шинэ шатыг бий болгоно.

Тус салбарын дунд хугацааны зорилтын хүрээнд:

1. Монголчуудын хүрээлэн буй орчин, технологийн тухай суурь судалгааг олон улсын чанарын түвшинд хүрэхүйц судалгааны үр дүнг бий болгоно. Цаашид, хот болон хөгжлийн асуудал зэрэг орчин үеийн Монголын нийгэм, соёлыг гол гол асуудлуудад анхаарал хандуулж, нийгэм-улс төрийн бодлого боловсруулах түвшинд хүрсэн судалгаа, эрдэм шинжилгээний үр дүнг олон нийтэд хүргэхээр ажиллана.

2. Эрдэм шинжилгээний судалгааны олон жилийн үр дүн ололт дээр тулгуурлан угсаатны зүйн судалгааны бүтээгдэхүүнийг инновацийн бүтээгдэхүүн болгон олон нийтэд таниулахад онцгойлон анхаарна. Монгол дахь аялал жуулчлалын салбарт Угсаатны зүй, биет бус соёлын өвийн чиглэлд суурилсан Угсаатны зүй, өв соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх цогц хөтөлбөрийг боловсруулж, Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн дэргэд гарааны компани (Start up) байгуулах боломжийг эрэлхийлж, компани байгуулах үндсэн үзэл баримтлалыг (concept) боловсруулан ажиллана.

Монгол угсаатны угсаа-гарвал, угсаатны бүрэлдэхүүний түүх, уламжлалт аж ахуй, зан заншил, эдийн болон оюуны соёлын өвийг гүнзгийрүүлэн судалж, өвлүүлэн уламжлуулах хөтөлбөр боловсруулах,

- *Монголчуудын угсаа гарвал, угсаатны бүрэлдэхүүнийг археологи, угсаатны судлал, нийгэм соёлын хүн судлал, генетикийн шинжлэх ухааны үүднээс цогцоор нь судлаж тодруулах, онол-арга зүйн чиглэлийг тодорхойлох, монголын судлаачдын үзэл баримтлалыг бий болгох*

- *Монгол угсаатны судалгааг зөвхөн монгол улсын хэмжээнд бус монгол туургатан болон бүс нутгийн нүүдэлчдийн түүхийн хүрээнд харьцуулсан судалгааг явуулах,*

- *“Монгол угсаатны өв” нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, тайлан материалуудыг цахим болгон нийтийн хүртээл болгох,*

- *Монгол угсаатны биет бус өвийн технологийг судлах, бүрэн бүртгэл явуулах, “Монгол угсаатны зүйн музей-лаборатори”-ийн үндсэн концепц гаргах*

- *Монгол угсаатны түүхэнд холбогдох баримт, аман түүх, хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүнийг бүсчилэн судлах*

Хамрах хүрээ. Нүүдэлчин монголчуудын уламжлалт ахуй бүхий өөрийн орны нутаг дэвсгэр болон хөрш зэргэлдээ улс орнуудад суурьшин амьдарч буй угсаатны бүлгүүдийн хүрээнд хамруулан авч үзнэ.

Өвөрмөц нөхцөл байдал. Монгол улсын хэмжээнд угсаатан судлалын чиглэлээр суурь судалгаа гүйцэтгэж буй цөөн эрдэм шинжилгээний нэгж бөгөөд хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүний баялаг цуглуулгатай юм.

Хөрөнгө оруулалт. Гадаадын хамтарсан төсөл болон үндэсний суурь судалгааны сэдэвт ажлаас хөрөнгө оруулалтыг бий болгоно.

Судалгааны багийн чадавхи. Тус салбар нь шинжлэх ухааны доктор 1, боловсролын доктор 2, магистр 4 гэсэн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Хэрэглээний угсаатан судлал, биет бус соёлын өвийн төвийн үйл ажиллагааны үндсэн чиглэл

Угсаатан судлал, биет бус соёлын өвийн чиглэлээр олон улс болон бүс нутгийн түвшинд судалгаа явуулж, Монголын язгуур ба уламжлалт соёлын ойлголтуудыг тодорхойлох үндэсний тэргүүлэх төв болно.

Тус салбарын дунд хугацааны зорилтын хүрээнд:

1. *Монгол Улсын соёлын өвийн тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон НҮБ-ийн холбогдох хөтөлбөр, зорилтуудын хүрээнд угсаатны зүйн суурин болон авран хамгаалах, биет бус соёлын өвийн судалгаа хийж эрдэм шинжилгээний мэдээллийн сан бүрдүүлэх судалгааны төв болох, .*

2. *Эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнг олон нийтийн хүртээл болгож танилцуулах улмаар холбогдох төрийн бодлогын хүрээнд зөвлөмж боловсруулна. Энэ нь үндэсний түүх соёлын дархлааг сэргээх улмаар соёлын аж үйлдвэрийг хөгжүүлэхэд суурь судалгааны үүрэг гүйцэтгэнэ.*

3. *“Монгол угсаатны Үндэсний музей” байгуулах судалгааны суурийг бүрдүүлэн ажиллаж улмаар тухайн эдийн болон оюуны соёлын өвийг танин мэдэхүй, судалгааны эргэлтэнд оруулах үйл ажиллагааг эрхлэн явуулах,*

4. *Орон нутгуудад хамтарсан хээрийн судалгааны газар, бүс нутгийн төвүүдийг байгуулах, тухайлсан сэдвүүдээр эрдэм шинжилгээний нэмэлт эх хэрэглэгдэхүүн цуглуулах, хамтран ажиллах сурвалжлагч гишүүдийг идэвхижүүлэх нэмэн ажиллуулах,*

5. *Орон нутгуудад амьдарч байгаа соёлын өв тээгч нарын бүртгэл хийхэд оролцох, судалгаа эрдэм шинжилгээний эх хэрэглэгдэхүүнээр хангах*

6. *“Монгол угсаатны өв” нэгдсэн мэдээллийн сан (database) бүрдүүлэх, орчин үеийн угсаатны нийгэм-соёлын үйл явц (өөрчлөлт, ижилсэл), соёлын биет бус өв, технологийн нөлөөллийг тогтоох, “Монгол угсаатны зүйн музей-лаборатори” үндэслэл боловсруулж, батлуулахад оршино.*

Хамрах хүрээ. Нүүдэлчин монголчуудын уламжлалт ахуй,соёлын судалгааг Монгол улсын болон хөрш зэргэлдээ улс орнуудад суурьшин амьдарч буй угсаатны бүлгүүдийн хүрээнд хамруулан авч үзнэ.

Өвөрмөц нөхцөл байдал. Монгол улсын хэмжээнд хэрэглээний угсаатан судлалын чиглэлээр ажиллах судалгааны нэгж бөгөөд үндэсний соёл, зан заншил, аж ахуй, уламжлал, шинэчлэлийг харуулсан үзмэрүүдээс бүрдсэн “Угсаатны судалгааны танхим”- ыг дэргэдээ байгуулж, цаашид лаборатори болгон өргөжүүлж сургалт, сурталчилгаанд ашиглах зорилт тавьж ажиллана.

Хөрөнгө оруулалт. Суурь судалгааны ба инновацийн төсөл, үндэсний хэмжээний соёлын өвийн судалгааны байгууллага, музей, орон нутгийн болон бизнесийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, авран хамгаалах судалгаа ба хандив тусламжаар бий болгоно.

Судалгааны багийн чадавхи. Тус салбарт боловсролын доктор 2, магистр 4 нарын 8 судлаачийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Сурвалж судлал, баримт, мэдээллийн төвийн үйл ажиллагааны үндсэн чиглэл

Монголын түүх-соёлын судалгааны баримт хэрэглэгдэхүүний үндэсний хэмжээний тулгуур төвийг буй болгож, түүхэн сурвалж, баримт бичиг, хээрийн шинжилгээний эх

хэрэглэгдэхүүн, гэрэл зураг, дуу, дүрс бичлэг, эд өлгийн зүйлс, дуртгал, дурсамжийн нэгдсэн сан бүрдүүлэх, “Монголын түүхийн шилдэг бүтээл”, “Монголын археологийн өв”, “Жуулчдын тэмдэглэл дэх Монголчууд”, “Дурсгалт бичгийн чуулган” зэрэг цувралуудыг нийтлүүлэх, Монголын түүхийн цахим номын сан, мэдээллийн бүртгэлжүүлэлт хийх,

- Түүхийн баримт мэдээлэлийн төвд хадгалагдаж буй монголын түүхийн судалгаанд хамаатай баримт, эх бичиг, материалуудыг цахимд шилжүүлж, гадаад, дотоодын эрдэмтэн судлаач, сонирхогчдод судлан шинжлэх боломж олгох;

- Гадаадын болон дотоодын архив, музей, судалгааны эрдэм шинжилгээний байгууллагууд, хувь хүмүүсийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа монголын түүх, соёлд холбогдох баримт, эх сурвалж, эд өлгийн зүйлс, гэрэл зургуудыг олж илэрүүлэх, судалгааны эргэлтэд оруулах, хамтран хэвлэн нийтлүүлэх зэрэг ажлыг гүйцэтгэх;

- Түүхэн үйл явдалд оролцсон хувь хүмүүсийн дуртгал гэрэл зураг, дуу дүрс, бичлэгээр сан хөмрөгөө баяжуулах;

- Баримт мэдээлэлийн сан хөмрөг хадгалагдаж буй баримтын жагсаалт цэсийг үргэлжлүүлэн хэвлэн нийтлүүлэх;

- Хүрээлэнгийн бусад салбаруудтай хамтран баримт бичгийн эмхэтгэл хэвлүүлэх,

- Номын сангийн эрэлт хайлт, үйлчилгээний бүрэн цахимжуулах;

Хамрах хүрээ. Хүрээлэнгийн бусад салбарууд мөн Үндэсний Төв архив болон аймаг, орон нутгийн байгууллагуудын архив, номын сан, музей, эрдэм шинжилгээний байгууллагууд, хувь хүмүүстэй хамтран ажиллана.

Өвөрмөц нөхцөл байдал. Монгол улсын түүхийг судалж, боловсруулж, бүхий л үеийн түүхийг туурвих явцад цуглуулсан түүх, археологийн ном, эх баримт, баримтын хуулбарууд байдаг.

Хөрөнгө оруулалт. Суурь судалгааны сэдэвт ажлын санхүүжилт, төсөл, захиалгат ажлаас санхүүжих боломжтой. Унгарын ШУА-тай хамтран Английн Британы Академийн дэмжлэгээр нэгдсэн сан үүсгэнэ.

Судалгааны багийн чадавхи. Тус төвд боловсролын доктор 2, магистр 2, бакалавр 2 ажиллаж байна. Боловсон хүчнийг чадваржуулах, сурвалж судалгаа, мэдээлэл технологийн ажилтнаар бэхжүүлж, эрдмийн зэрэгтэй ажилтны тоог нэмэгдүүлэх шаардлагатай. Одоогоор Эрдэм шинжилгээний ажилтан, мэдээлэл технологийн ажилтан дутагдалтай байна.